



Дэлхий дахины
удирдагчдын сургалт
“Үр удмаа зөв шударга
төлөвшүүлэх нь”

2008 ОНЫ ХОЁРДУГААР САРЫН 9

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргав
Юта мужийн Солт Лейк хот

© 2008 by Intellectual Reserve, Inc.
Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн нэгдсэн улсад хэвлэв.

Англи хэлний зөвшөөрөл : 5/07
Орчуулгын зөвшөөрөл: 5/07

"Үр удмаа зөв шударга төлөвшүүлэх нь" Дэлхий дахины удирдагчдын сургалтын орчуулга, 2008 оны хоёрдугаар сарын 9
06761 363

СЭДВҮҮД

| | |
|---|----|
| Өвөрмөц амьдрал болон ерөнхий загварууд | 2 |
| <i>Ахлагч Жэффри Р.Холланд</i> | |
| Гэр бүл дээр тулгуурласан тунхаг бичиг | 4 |
| <i>Ерөнхийлөгч Бойд К.Пакер</i> | |
| Дугуй ширээний ярилцлага | 10 |
| <i>Ахлагч Даллин Х.Өүкс</i> | |
| <i>Ахлагч Жэффри Р.Холланд</i> | |
| <i>Жули Б.Бек</i> | |
| <i>Сюзан В.Таннер</i> | |
| <i>Шерил С.Лант</i> | |
| Дэлхийгээс хоргодох газар | 29 |
| <i>Ерөнхийлөгч Томас С.Монсон</i> | |

Өвөрмөц амьдрал болон ерөнхий загварууд

АРВАНХОЁРЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЧУУЛГЫН

Ахлагч Жэффри Р.Холланд



Гэр бүлийг дэмжих нь

Ах эгч нар аа, 2008 оны дэлхий дахины удирдагчдын сургалтын шууд нэвтрүүлэгт тавтай морилно уу. “Үр удмаа зөв шударга төлөвшүүлэх нь” сэдэвт ярилцлагад анхаарлаа хандуулна уу. Бид “Гэр бүлийг дэмжих нь” сэдвээр 2 жилийн өмнө нэвтрүүлэг явуулж байсан билээ.

Гэр бүлийг бэхжүүлэх, хамгаалах нь ямар чухал болох талаарх тэргүүн зөвлөлийн захидлууд, мөн захиасуудыг та нар сонссон байгаа. Ариун

ёслолын цуглаан дээр уншиж, гэр бүлүүдэд хүргэсэн байх ёстой энэ захидлуудын нэгэнд: “Хүүхдүүдцээ сайн мэдээний зарчмуудыг зааж, хүмүүжүүлэхэд бүхий л хүч чармайлтаа гаргахыг эцэг эхчүүдэд бид уриалж байна” гэсэн үгс байгаа. . . Бусад олон, үйл ажиллагаанууд байж болох ч гэсэн, зөвхөн эцэг эхчүүд, гэр бүлүүдэд бурханлигаар томилогдсон үүргүүдийг нь тэдгээр зүйлүүд орлох ёсгүй.

Бид энэхүү нэвтрүүлийг Сүмийн бүх насанд хүрэгчдэд зориулж байна. “Үр удмаа зөв шударга төлөвшүүлэх” тухай ярилцахад ганц бие залуу насанд хүрэгчдийг урьсан нь тэдэнд хачирхалтай санагдаж болох юм. Гэвч бид тэдэнд урилгыг зориуд хүргүүлсэн юм. Ганц бие насанд хүрэгчид та нар ирээдүйд эцэг эх болох бөгөөд болох ч ёстой. Гэр бүлтэй болоход бэлтгэж байгаа ч гэсэн өөрсдийнхөө эцэг эхийн хувьд өнөөдөр, бас ирээдүйд ч үр хүүхэд нь л байна шүү дээ. Сүм болон эцэг эхчүүд чинь дэмждэг гэр бүлийн зарчмуудад та

бүгдийг бие сэтгэлээ зориулахын төлөө бид залбирч байна.

Энд байгаа мөн Сүмийн зарим хүмүүс одоохондоо гэрлээгүй юмуу эсвэл Сүмд, бидний тогтмол ярьдаг шиг төгс гэр бүлгүйг бид мэднэ. Манай гишүүдийн дунд байдаг олон өөр нөхцөлүүдийг бид бүрэн дүүрэн ойлгодог гэдэгт итгэлтэй байгтун. Та нарт бид хайртай. Гэрлэлт, үр хүүхэд, гэр бүлийн амьдралыг дээдэлдэггүй зан заншлын улмаас олон гэр бүл эмх цэгцгүй байгааг бид бас мэддэг. Иймээс Ерөнхий эрх мэдэлтнүүд, Сүмийн ерөнхий ажилтнууд сайн мэдээн дээр тулгуурласан зарчмуудын тухай байнга ярьдаг. Эс бөгөөс, гэрлэлт болон мөнхийн гэр бүлийн жишгүүдийг баримтлахад, ёс суртахуунаас дэлхий алгуураар гажиж байгаа өнөө үед бид, Сүмийн болон сүмийн биш хүмүүс үнэхээр чиг баримжаагүй болж байна.

Хуулбар болон загварууд

Та нарын гэр бүлийн байдал ямар ч байж болно, ийм нөхцөлийг харуулж чадах нэгэн сургаалт зүйрлэлийг хуваалцъя. Үүнийг “Гар хийцийн цамцны тухай сургаалт зүйрлэл” гэж нэрлэе. Ээж минь чадварлаг оёдолчин байсан юм. Намайг бага байхад манайх мөнгө муутай байсан болохоор ээж минь бидний сургуульд өмсөх зарим хувцсыг оёдог байлаа. Дэлгүүрийн цонхон дээр юм уу хувцасны каталогаас би нэг цамцыг сонгоход ээж маань, “Би үүнийг оёж чадна шүү” гэдэг байлаа. Ээж цамцыг хараад, дараа нь даавууг

эсгэж, яг таарсан, бүр нөгөөх каталогт байсан шиг цамц хийчихдэг байж билээ.

Надад цамц оёж өгөхийг зөвшөөрдөг байсанд нь, бас оёж өгч чаддаг байсанд нь би ээждээ талархдаг юм. Харин ээж ингэж оёх дургүй байв. Тэр эсгүүр хэрэглэн оёх дуртай байлаа. Эсгүүр нь өнцөг булан болон нарийн оёдол шаглаасыг гарган оёход ээжид минь тусалдаг байсан юм билээ. Түүнээс гадна, ээж хоёр, гурван цамц оёх боллоо гэхэд ямагт эх загварын төгс байдлаас санаа аван илүү сайжруулж оёдог байлаа.

Та нар миний юу гэж хэлэх гэж байгааг ойлгож байгаа биз дээ. Хэрэв нэг цамцыг нөгөө цамцтай дуурайлгаж, мөн энэ цамцыг өөр нэг цамцнаас хуулбарлаж хийх юм бол бид хэрэггүй юм хийж байгаа нь тэр. Эхний цамцан дахь алдаа эсгүүр хэрэглээгүйн улмаас дараагийн цамцанд давтагдаж нэмэгдсэнээр сургуульд өмсөх хувцас маань таарахаа болно гэсэн үг. Нэг ханцуй нь урт, нөгөө нь богино нэг мөрний оёдол цээж рүү, нөгөө нь нуруу руу унжаад, захны товч нь шилэн хүзүүн дээр гарсан байвал ямар байх вэ. Өсвөр насны хүүхэд ийм хувцастай явбал бусдын элэг доог болно биз дээ.

Бурханаас ирэх төгс загвар

Бид гэрлэлт, гэр бүлийн тухай ярихдаа яагаад төгс загварын тухай ярьдгийг ойлгоход энэ нь та нарт тусална гэдэгт би найдаж байна.



Загвар нь Бурханаас ирдгийг бид бүгд хүлээн зөвшөөрч, үүний төлөө чадах бүхнээ хийхийг хичээх учиртай.

Эдүгээ хүн бүр ийм нөхцөлд амьдардаггүй шүү дээ. Учир нь төгс чанарыг олон хүн огт мэддэггүй бас ёс заншлын зарим хүчин зүйлүүд Тэнгэрлэг Эцэгийн мөнхийн төлөвлөгөөндөө хүртээсэй хэмээн хүсдэг төгс сайхан зүйлсээс биднийг байнга холдуулж байдаг юм.

Гэрлэлтийн байдал, гэр бүлийн тухайн нөхцөлд хувь хүмүүс дасан зохицох ёстой. Гэвч загвар нь Бурханаас ирдгийг бид бүгд хүлээн зөвшөөрч, үүний төлөө чадах бүхнээ хийхийг хичээх учиртай.

Бурханы ерөнхий дүрмүүдийг Ерөнхий эрх мэдэлтнүүд, ерөнхий ажилтнууд заахаар дуудагддаг. Та бид өөр өөр амьдралтай, иймээс тухайн нөхцөл байдлуудын талаар Их Эзэний удирдамжийг эрэлхийлэх ёстой. Гэвч, хэрэв төгс сайн гэж байхгүй бол, сургаалын жишиг бий болж давтагддаггүй бол, нийтийг

хамарсан төөрөгдөл бий болж, сайн мэдээний амлалтууд үгүй болох биз ээ. Их Эзэн эдгээр асуудлын талаар ярьдгийг мэдсэнээр бид сүнсээр өсдөг бөгөөд бид түүний зөвлөгөөг хүлээн авдаг.

Та нар хэдэн настай байх нь хамаагүй, яагаад гэр бүлийн бүх гишүүдийг хамгаалахаар санаа тавьдгийг, Бурханы аз жаргалын мөнхийн төлөвлөгөөний аль нэг талыг устгахыг хичээдэг хүчнүүдийн эсрэг бид ярьдгийг ойлгодогт баярлалаа. “Та нар мэхлэгдэхгүй байж болохын тулд би та нарт бүх зүйлд загвар өгнө” (С ба Г 52:14) гэж ЭЗЭН хэлсэнд бид маш их талархалтай байдаг билээ.

ТЭМДЭГЛЭЛ

1. Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг, 1999 оны хоёрдугаар сарын 11

Гэр бүл дээр ТӨВЛӨРСӨН ТУНХАГ

ЕРӨНХИЙЛӨГЧ БОИД К.ПАКЕР

Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч



Тодорхой бус санаанууд

Би энэ цуглаанд оролцож байгаадаа баяртай байна. Дэлхий дахинаа болж байгаа энэхүү хүндэтгэлтэй үйл явдлыг тохиолдуулан та бүгдэд мэндчилье. Сүмийн удирдлага биднээс та бүгдэд хүргэж чадах сэдвээс хамгийн чухал нь энэ сэдэв байх.

Дэлхийн чиг хандлагаас болж гэр орон, гэр бүлийнхээ төлөө санаа зовних чинь нэмэгдэж байгааг бид мэдэж байна. Есүс Христийн

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол сэргээгдсэн Сүм бөгөөд Эцэг Хүү хоёр Бошиглогч Иосеф Смит дээр хүрч ирснээр эхлэл нь тавигдсан юм. Тэрхүү агуу анхны үзэгдэлд байсан хоёр дүр төрх, хоёр гайхамшигтай санаа тэр үеэс хойш бий болж, Сүмийн хувьд удирдамж болсоор ирснийг бид мэднэ.

Эхнийх ньэцэг юм. Бурхан өөртөө өгч болох бүх нэрсээс бид бүгдэд хамгийн ойр дотно нэрийг сонгосон ажээ. Тэр бол бидний Эцэг юм. Энэ нэрийг хүлээн зөвшөөрсөн болохоор бид Бурханы хүүхдүүд юм. Хүү нь тэнд байснаар энэ нь гэр бүлийг танилцуулсан юм. Мөн үүний тулд Эцэг Хүү хоёр хүрч ирсэн билээ.

Түүнээс хойш удалгүй өгсөн нэг илчлэлтэд Их Эзэн, “Иймийн тул, Их Эзэн бибээр, дэлхийн оршин суугчид дээр ирэх тэрхүү сүйрлийг мэдэх учраас, өөрийн үйлчлэгч Бага Иосеф Смитийг дуудан тэнгэрээс түүнд ярьж, мөн түүнд зарлигуудыг

өгсөн ажгуу” (С ба Г 1:17) хэмээн хэлсэн байдаг.

Илчлэлтийн дагуу амьдрах нь

Энэ бол эхлэл нь байлаа. Энэ бол Их Эзэний өгсөн илчлэлтүүдийн дагуу бид үйлдэж, зохион байгуулж, ажиллах ёстой тэрхүү загвар байв. Сургаал ба Гэрээ номонд эмхтгэл болон орсон эдгээр илчлэлтүүд, мөн Мормоны Ном, Агуу Үнэт Сувд судар дахь илчлэлтүүд Сүмийн хувьд судрын үндэс суурийг бүрдүүлдгийг та бүгд мэдэх билээ.

Их Эзэн нь Сүмийг дэлхийн бусад Сүмүүдийн загвараар зохион байгуулаагүйг бид мэднэ. Манай Сүмд мэргэжлийн шашны ажилтан байдаггүй. Сүмийг удирдах эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг бэлтгэдэг семинарууд байдаггүй. Энэ нь “Хүн болгон Их Эзэн Бурханы . . . , бүр дэлхийн Аврагчийн нэрээр ярьж болохын тулд юм” (С ба Г 1:20) хэмээн нэг өгүүлбэрээр нэгтгэн хэлсэн байдаг.

Санваар эзэмшигч ах нар, тэдний дэргэд байдаг эмэгтэйчүүдийн тэгш байдлыг бид эндээс олж хардаг. Бид хамтран ажилладаг бөгөөд юуны түүрүүнд гэр бүлүүд болон зохион байгуулагддаг билээ. Сүнслэг нөлөө болон илчлэлтийн эрх бид бүгдэд байдаг. Энэ нь гэр бүлийг бий болгон төлөвшүүлэхэд энэ дэлхийд хичнээн их хэрэгтэй байгаа билээ.

Үр удмаа зөв шударга

төлөвшүүлэх нь

Иймээс энэ цуглааны сэдэв нь үр удмаа зөв шударга төлөвшүүлэх



Адам Ева хоёрт өгсөн анхны зарлиг бол өсөн үржиж, газар дэлхийг дүүргэх явдал байсан. Энэхүү загвар нь хүн төрөлхтний түүхэнд үргэлжилсээр байгаа билээ.

болон үүнд хүлээх үүрэг хариуцлагын тухай юм. Адам Ева хоёрт өгсөн анхны зарлиг бол өсөн үржиж, газар дэлхийг дүүргэх явдал бөгөөд газар дэлхийг дүүргэх үйл явц нь тэдний бие махбодод нь өгөгдсөн ажээ. Ингээд уг загвар хүн төрөлхтний түүхийн бүх үед үргэлжилсээр ирсэн юм.

Ийнхүү анхны гэр бүл—Адам түүний эхнэр, дараа нь тэдний хүүхдүүд юм. Тэнгэрт бослого гарч, дайн болж Сатан хөөгдөн, Бүхнийг Чадагчийн ажлуудыг устгахаар нэгэнт шийдснийг, мөн устгалаа эхлэх хэсэг нь гэр бүл гэдгийг тэрээр сайн мэдэж байсныг бид мэднэ. Үүнийг Адам Ева хоёрын шастираас бид мэдэж авдаг билээ.

Дэлхий дахинаа өргөх тунхаг

Саяхнаас дэлхийд гэр бүлийн асуудлаарх хөдөлгөөн бий болсон

билээ. Улмаар Нэгдсэн Үндэсний Байгууллага Хятадын Бээжин хотод гэр бүлийн асуудлаар зөвлөгөөн хийсэн. Гэр бүлийн асуудлаарх уг зөвлөгөөн болон өмнө нь болж байсан бусад зөвлөгөөнүүдэд бид төлөөлөгчдөө илгээдэг байсан. Ээлжит зөвлөгөөнүүдийн нэг нь манай төв байгууллагад ойрхон болохоор зарлагдахад, “Хэрэв тэд энд ирвэл, бид өөрсдийгөө олон нийтэд илүү сайн тунхаглаж болох юм биш үү? гэж бид бодож билээ.”

Сүмийн гэр тунхаг маш чухал, том хэмжээний мэдэгдэл байлаа. Эдгээрийн цөөн заримыг нь Сүмийн эхэн үед зарлан мэдэгдсэн юм. Энэ нь чухал, илчлэлтийн шинжтэй юм. Тэр үед “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийг гаргаснаас хойш арван жил гаруйхан болоод байлаа. Тунхгийг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд бичсэн бөгөөд суд-

рын адил хүчтэйг би та бүгдэд хэлж чадна.

Одоо та нар гэр бүлийн тунхгаас иш татсан үгсийг сонсох болно. Үүнийг та нарт уншиж өгөх нь их ач холбогдолтой гэж би бодож байна. Бид та нарыг тунхгийг өмнө нь уншиж байсан гэдгийг мэднэ. Гэвч бид үүнийг удаан, анхааралтайгаар уншиж, эргэцүүлэн бодох юм бол, байгаа гэж бодсоноосоо илүү олон илчлэлтийг олж мэдэх болно.

Бид яагаад ийм байдалтай байдаг, бид хийдэг зүйлүүдээ юуны учир хийдэг, яагаад бид хийдэггүй зүйлүүдээ хийдэггүй болохыг эргэцүүлэн бодох юм бол, гэр бүлийн энэ тунхагт харуулсан эрх мэдлийг та нар олж харж чадна. Нийгэмд жишиг болон тогтсон мэт бодогд-

дог зүйлүүдийг хийгээгүйн улмаас, чанд хатуу байсныхаа төлөө зэмлэл хүлээх үе бидэнд байдаг. Хийх ёсгүй зүйлүүдийг бид хийдэггүй, учир нь бидний баримталдаг жишгийг Тэрбээр өгсөн билээ.

Тунхгийг би та нарт уншиж өгье, харин та нар үүнийг сонсоод, эдүгээ нийгэм, улс төр, төр засаг, шашны хувьд хамгийн их анхаарал татдаг, хүндрэл бэрхшээлийг үүнд дурдсан болохыг та нар ойлгох болно. Мөн та нар тэндээс хариуг нь олох болно. Эдгээр хариултууд нь Сүмийн хариултууд юм.

“Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”

“Есүс Христийн Хожмын үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгч

“Есүс Христийн Хожмын үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөлийнхөн бид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтийг Бурхан томилдог бөгөөд гэр бүл нь Түүний [бүх] хүүхдүүдийн мөнхийн хувь тавилангийн төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг хүндэтгэлтэйгээр тунхаглаж байна.”

Өмнөх амьдрал

Бидэнд илчилсэн сургаалуудаас мөнх бус байдлын өмнөх оршихуй бидэнд байсныг мэдэж авдаг билээ. Газар дэлхийд хүн төрөлхтнийг илгээснээр бүх зүйл эхлээгүй юм. Түүнчлэн сайн мэдээний сургаалууд Бошиглогч Иосеф Смитэд илчлэгдэхдээ ч шинэ зүйл байгаагүй юм.



Эдгээр сургаалууд үүрд мөнхөөс байсан, мөн үүрд мөнхөд байх болно. Одоо анхааралтай сонсоно уу.

“Бурхан бүх хүн төрөлхтөн, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг Өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн юм. Хүн бүр тэнгэрлэг эцэг эхийн хайртай сүнсэн хүү, охин нь бөгөөд, ийм учраас хүн бүр бурханлиг шинж чанар, хувь тавилантай юм. Хүйс бол хувь хүний мөнх бус байдлын өмнөх, мөнх бус болон мөнх амьдралын тодорхойлолт ба зорилгын салшгүй хэсэг юм.”

“Мөнх бус байдлын өмнөх амьдралд сүнсэн хөвгүүд, охид Бурханыг Мөнхийн Эцэг мэддэг, биширдэг байсан бөгөөд мөнх амьдралыг өвлөн авах тэнгэрлэг хувь тавилангаа бүрэн дүүрэн ойлгож, төгс төгөлдөр болон хөгжин дэвшихийн тулд бие махбодтой болж, энэ дэлхийд амьдрах тухай Түүний төлөвлөгөөг хүлээн зөвшөөрсөн юм. Аз жарга-

лын тэнгэрлэг төлөвлөгөө нь насан эцэслэсний дараа гэр бүлийн холбоог мөнхжих боломжийг олгодог.”

Аз жаргалын агуу төлөвлөгөө

Энэ нь үүнийг аз жаргалын төлөвлөгөө хэмээн дүрсэлснийг ажиглагч тун. Энэ нь Мормоны Номонд “аз жаргалын агуу төлөвлөгөө” (Алма 42:8) гэж дүрслэгдсэн байдаг.

“Ариун сүмүүдэд гүйцэтгэдэг ариун нандин ёслол ба гэрээнүүд нь хувь хүмүүс Бурханы оршихуйд эргэн очих, гэр бүлүүд мөнхөд нэгдэх боломжтой болгодог.”

“Бурхан Адам Ева хоёрт өгсөн анхны зарлиг нь эхнэр нөхрийн хувьд эцэг эх болж чадах боломжийн талаар байлаа. “Өсөн үржиж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэ” хэмээн хүүхдүүддээ өгсөн Бурханы зарлиг хүчин төгөлдөр хэвээр байгааг бид тунхаглаж байна. Түүнчлэн үр удмаа үлдээх энэхүү ариун нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр нөхөр хоёр болох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой хэмээн Бурхан зарлигласныг тунхаглаж байна.”

Тунхгийг эхнээс нь дуустал уншихад, өмнө өгүүлэгдсэн зүйлүүд тунхаглагдсаныг та нар ажиглах болно. Дэлхий үүнийг өөрчлөхийг хүсдэг. Бид бол үгүй. Бид ингэж болохгүй. Бид хэн бэ? Бид яагаад энд байгаа юм бэ? гэдгийг эргэцүүлэн бодох юм бол бидэнд өгөгдсөн загвар байдаг ба бид үүнийг баримтлах болно.

“Мөнх бус амьдралыг бий болгох арга зам нь Тэнгэрээс тогтоогдсо-

ныг бид тунхагладаг. Бурханы мөнхийн төлөвлөгөөн дэх амьдралын цэвэр ариун байдал болон үүний ач холбогдлын талаар бид батлан хэлж болно.”

Илчлэлтүүдэд болон гэр бүлийн тунхагт нотлогдож, томъёологдсон гэр бүл салалт, үр хөндүүлэлт, хүйсийн асуудлууд дээр яагаад бид ийм байр суурьтай байдгийг та нар эргэцүүлэн бодох нь бид эдгээр асуудлуудын хариуг олох хамгийн тод нотолгоо юм.

Эцэг эхийн үүргүүд

“Нөхөр, эхнэр хоёр бие биенээ болон үр хүүхдээ хайрлан, халамжлах албан ёсны үүрэг хүлээнэ. ‘Үр хүүхэд бол Их Эзэний өв юм’ (Дуулал 127:3). Эцэг эхчүүд хүүхдүүдээ хайраар болон зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлж, бие бялдар болон оюун санааных нь хэрэгцээг хангаж, бие биенээ хайрлан, үйлчилж, Бурханы зарлигуудыг даган, хаана ч амьдарсан хуулийг дээдлэн сахидаг иргэд байхыг зааж сургах ариун үүрэгтэй юм. Эхнэр нөхөр—эцэг эхчүүд үүргээ хэрхэн биелүүлснээрээ Бурханы өмнө хариуцлага хүлээнэ.

“Гэр бүл Бурханаас томилогддог. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүл болох нь Түүний мөнхийн төлөвлөгөөний зайлшгүй чухал хэсэг юм.”

Эрэгтэй хүн, эмэгтэй хоёрын хоорондын гэрлэлтээс өөр гэрлэлтийн загвар байх

ёсгүйг бид Сүмд хүлээн зөвшөөрдөг.

“Хүүхдүүд гэр бүлд төрж, гэрлэлтийн тангаргаа үнэнчээр сахидаг эцэг эхээр өсгүүлэх эрхтэй юм. Их Эзэн Есүс Христийн сургаал дээр үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно.”

Сүмийн бүх үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийн зорилго нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон тэдний аз жаргалтай гэр бүлээс хамааралтай байдаг гэж би үргэлж боддог

“Аз жаргалтай гэрлэлт болон аз жаргалтай гэр бүлүүд нь итгэл, залбирал, наманчлал, уучлал, хүндэтгэл, хайр энэрэл, өрөвч сэтгэл, эрүүл саруул идэвхтэй амралтын үйл ажиллагаануудын зарчмууд дээр оршин амьдардаг. Тэнгэрийн загвараар эцэг нь өрх гэрээ хайр, зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, амьдралын хэрэгцээт зүйлсээр нь хангаж, гэр бүлээ хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар

өсгөн хүмүүжүүлэх явдал юм.

Энэхүү ариун үүргээ биелүүлэхэд эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой. Тахир дутуу болох, нас нөгчих болон бусад нөхцөл байдалд хувь хүн зайлшгүй дасан зохицох шаардлага гарч болно. Төрөл төрөгсөд нь шаардлагатай үед туслан дэмжих хэрэгтэй

Анхааруулж байна

“Анхааруулж байна” гэдэг үгийг бид олон удаа хэрэглээд байдаггүй л дээ гэвч энд энэ үг тохиромжтой юм. “Ариун явдлын гэрээгээ зөрчин, хань ижил, үр хүүхэдтэйгээ зүй бусаар харьцсан, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй хувь хүн хожмын нэг өдөр Бурханы





Энэ амьдралд гэр бүлийн амьдрал зохиож, хүүхэд өсгөх гэдэг тийм амар биш. Харин сүмээс та хэрэгтэй тусламжийг олж авч чадна.

өмнө өчиг мэдүүлнэ гэдгийг бид анхааруулж байна. Түүнчлэн гэр бүлээ сарниулбал, эрт эдүгээгийн бошиглогчдын зөгнөн хэлснээр хувь хүн, нийгэм, улс үндэстнүүдэд гай гамшиг авчрах болно гэдгийг бид сануулж байна.

“Итгэл хүлээсэн иргэд, төрийн албан хаагч та бүхнийг нийгмийн үндсэн нэгж болох гэр бүлийг бэхжүүлэн авч явах эдгээр арга замыг ямагт хэрэгжүүлэгчтүн” хэмээн уриалан дуудаж байна.

Сургаалууд болон ёслолууд

Одоо та нар Сүмийн хэмжээнд хийж байгаа сургалтын энэ цуглаан дээр танилцуулах практик хэрэглээ, заавар, зөвлөгөө, удирдамжийг сонсох болно. Энэ бүгд нь судрын

илчлэлтүүд, гэр бүлийн энэ тунхагт тунхагласан сургаал болон зарчмууд дээр төвлөрдөг юм.

Залуу хүмүүс та нар гэрлэхийг, бас гэр бүлийн амьдралыг хүсэн хүлээж байгаа бол, мөн аюулыг харж байгаа бол, гэр бүл бүрэн хамгаалагдаж чадах цорын ганц газар энэ дэлхий дээр байдаг, энэ нь Есүс Христийн сайн мэдээний ёслолууд, сургаалуудын хүрээнд байдаг. Сайн мэдээгээр амьдар, тэгвэл та нарын хувьд бүх зүйл сайн байх болно.

Дэлхий бол амьдрахад тийм ч таатай газар биш юм, энд сорилт бэрхшээл, өвчин эмгэг, амьдрал, үхлийн загварууд, түүнчлэн бидэнд тохиолддог бүх асуудлууд байдаг гэвч, эдгээрийн хариулт нь Сүмийн үндсэн гол нэгж гэр бүл мөн гэд-

гийг ойлгоход оршдог. Сүмийн бүх үйл ажиллагаа гэр бүлийг бэхжүүлэх зорилготой юм.

Гэр бүлд үзүүлэх тусламж

Сүмийг дэмжих үүргийг гэр бүлүүдэд ноогдуулснаараа заримдаа бид гэр бүлийг дэмжих байр сууринаасаа яльгүй хазайдаг. Залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдийг гэр бүлийн амьдралд урьдаас бэлтгэж, гэрлэсэн анхны жилүүдэд нь, мөн нас өндөр болтол нь туслахад Сүмийн үйл ажиллагаанууд, хөтөлбөрүүдийг зохион байгуулахад орон нутгийн удирдагчдад санаа тавих хэрэгтэй байна.

Нас ахих нь миний төсөөлж байснаас өөр болохыг би олгож эхэлж байна. Хайр, гэр бүлийн хэлхээ холбооны загварын тухай, залуучуудын оргилуун хайрын талаар би эргэцүүлж боддог. Үүнийг хадгалан хамгаалж болох уу? Мэдээж, бололгүй яахав. Үүнийг зөвхөн хадгалж хамгаалах төдийгүй, өндөрт өргөж, эрхэмлэн дээдлэх хэрэгтэй. Энэ амьдралд гэр бүлийг бий болгож, үр хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх нь амар хялбар биш юм. Харин Сүмтэй хамт байхад та нар хэрэгтэй тусалцааг авах болно.

Одоо үед гэр бүлийн амьдрал зохиож, хүүхэд өсгөнө гэдэг тийм амар биш. Харин Сүмтэй бол та хэрэгтэй тусламжаа олж чадна

Би хэдийгээр ач гуч, зээ, зээнцэрүүдтэй ч Сүм биднээс юу хийхийг хүсэн хүлээж байгааг мэдэхийг тулд орон нутгийн санваартны удирдагч-

дад хандах хэрэгтэй болдог. Харин зарим үед сорилт бэрхшээл, аюул осол, сэтгэл санаагаар унах нь бий. Эдгээр зүйлүүдэд туслахын тулд л Сүм байдаг юм. Гэр бүлийг хамгаалахын тулд Сүмд бид чадах бүхнээ хийхийн сацуу санваартны удирдагчид мөн Сүм байдаг улс орон бүрийг төлөөлдөг хүч дэлхий даяар байдаг. энэ бол санваартан эрэгтэйчүүд, эх хүний зөн билигтэй, ухаалаг ялдамхан эхчүүд—эмэгтэйчүүд юм.

Хүүхдүүд маань төрсөн гэр орноо орхин, алс холын хотод гэр бүлээ бий болгохоор явахад нь бид тэднийг хараад, “гэр газар тэд гэр орон гэр бүлээ төвхнүүлнэ” шүү дээ гэж бодоход дотор онгойж, сэтгэл тайвширдаг билээ. “Үнэ өртөг өндөр учраас та нар бидэнтэй байнга утсаар яриад байх хэрэггүй. Та нарт тэнд нэг эмээ байх болно. Тэр эмээг та нар хаанаас олох вэ? гэвэл Нийгмийн Халамжийн Бүлгээс. Та нар бас ухаалаг зөвлөгөө сонсож, төрсөн гэр орондоо байсантай адил тийм хүч чадлыг олох боломжтой байх болно. Та нар гэр бүлээ өсгөн үржүүлэхээр тийшээ явж байгаа юм шүү дээ” гэж бид хүүхдүүддээ олон удаа захиж хэлдэг билээ.

Хэрэв та нар энэ хуралдаан дээр өгөх зааврыг сонсох юм бол, тэндээс сүнсний нөлөө, удирдамжуудыг олох болно. Есүс Христийн Хожмын үеийн Гэгээнтнүүдийн Сүмд бид баптисм хүртэх үед, баптисмаас тусдаа өөр нэг ёслол болох Ариун Сүнсний бэлэгийг өгдгийг бид бас мэднэ. Эрх мэдэл бүхий ах

нар баптисм хүртсэн хүн бүрийн толгой дээр гараа тавин, энэ бэлгийг олгодог бөгөөд амьдралын маань туршид энэ бэлэг бидний хувьд гэрэл, багш, залруулагч, хөтөч болдог.

Удирдамж болон адислалууд

Энэ нь айдаст амьдрахыг, бас эргэн тойрондоо болж байгаа бүхнийг хараад, “Бидний эргэн тойронд бүх төрлийн уруу таталт, ийм их бэрхшээл байхад бид яаж гэр бүл бий болгож, өсгөн өндийлгөж чадах юм бэ?” гэж Сүмийн гишүүдийг хэлнэ гэж би бодохгүй байна.

Ингэхэд, та нар өөрсдөө үүнийг чаддаг учраас, та нар удирдагдаж чаддаг учраас, та нар хэрхэн удирдуулдаг байхыг хүүхдүүддээ зааж, энэ бүгдийг хийснээр та нар аз жаргалтай амьдарч чадна, мөн гэр бүл хамтдаа байж чадах дараагийн оршихуйд төгс байдлыг олж чадах болно.

Заримдаа гэр бүлийн гишүүд маань Сүмийн гишүүн биш байх буюу Сүмд идэвхгүй болдог. Хэрэв тэд ариун сүмийн ёслолуудаар лацдан холбуулсан бол, гэрээнүүдээ сахидаг байсан бол, тэд бүрмөсөн алдагдахгүй, цаг нь болоход, засч залруулах шаардлагатай бүхнийг хийсний дараа, тэд алдагдахгүй гэсэн бошиглогчдын амлалт бидэнд байдаг билээ.

Иймээс Сүм даяарх та бүгдэд, гэр бүлийн амьдралын аз жаргалыг эдэлж байгаа эцэг эхчүүд, хүүхдүүдэд би адислалуудаа өгч байна. Та нар адислагдаж, та нарт анхаарал

халамж тавьдаг байх тэрхүү загвар та нарынх юм. Ариун Сүнсний хүч амьдралд тань байж, санваарын хамгаалах хүч та нарыг засч залруулан, та нарыг адисалж, урамшуулан дэмжиж, туслан, гэрчлэлийг тань та нарт бат бөх болгох болно.

Бурхан бол бидний Эцэг


Бурхан амьдыг, Тэрээр бидний Эцэг гэдгийг, тийм ээ, Тэр бидний Эцэг гэдгийг би мэднэ. Энэ үгийг хэрхэн хэлэх учиртайг би төдийлөн сайн мэдэхгүй байна. Энэ бол бидний ямагт ухаалгаар хэлдэг үг. Гэвч Тэр бол бидний Эцэг. Тэр бидэнд хайртай. Мөн энэ загварын талаар, Сүмийн бүх гишүүдтэй, мөн гишүүн болж болох бүх хүмүүстэй нэгэн адил санаа бодол Сүмийг удирддаг бидэнд бас байдаг билээ. Иймээс зөвшударга үр удмаа өсгөн хүмүүжүүлэхэд сүмийн гишүүний хувьд үүрэг хариуцлагатай тулгардаг та нар дээр Их Эзэний адислалуудыг, мөн Эцэгийн адислалуудыг би хүсэн гуйж байна, Есүс Христийн нэрээр, амен.

ТЭМДЭГЛЭЛ

1. “The Family: A Proclamation to the World,” *Ensign*, Nov. 1995, 102.

Дугуй ширээний ярилцлага

АХЛАГЧ ДАЛЛИН Х.ӨУКС АРВАНХОЁР
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЧУУЛГЫН



АХЛАГЧ ЖЭФФРИ Р.ХОЛЛАНД
АРВАНХОЁР ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЧУУЛГЫН



ЖУЛИ Б.БЭК НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН
БҮЛГИЙН ЕРӨНХИЙ ЕРӨНХИЙЛӨГЧ



СЮЗАН В.ТАННЕР ЗАЛУУ ЭМЭГТЭЙЧҮҮ-
ДИЙН ЕРӨНХИЙ ЕРӨНХИЙЛӨГЧ



ШЕРИЛ С.ЛАНТ ХҮҮХДИЙН ХЭСГИЙН
ЕРӨНХИЙ ЕРӨНХИЙЛӨГЧ

Бүтээгчийн төлөвлөгөө

Ахлагч Холланд

Арванхоёрын Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс. НХБ-ийн ерөнхий ерөнхийлөгч Жули Бек эгч, Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Сюзан Таннер эгч, Хүүхдийн Хэсгийн ерөнхий ерөнхийлөгч Шерил Лант эгч нар бидэнтэй хамт байгаад баяртай байна. Эдгээр удирдагчид намайг өөрсөдтэйгөө нэгдэхийг урьж, ярилцлагыг намайг удирдан явуулахыг хүссэн юм

“Эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын гэрлэлт Түүний мөнхийн төлөвлөгөөний төвд байдаг” гэсэн үгс дэлхий дахинд хандсан тунхагт байдаг. Сүм дэх гэрлэлт, гэр бүлийн тухай бид ярихдаа яагаад үүнийг Бурханы төлөвлөгөөтэй холбож үздэг вэ? Яагаад бид үүнийг үүрд мөнхтэй, бас авралын нийт төлөвлөгөөтэй холбож үздэг вэ?

Ахлагч Өүкс

Гэр бүлийн тунхагаас дахин иштатъя. “Гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь тавилангийн төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдаг.” Гэрлэлт болон хүүхдүүдийг төрүүлж өсгөн хүмүүжүүлэх талаарх бидний шийдвэр, хүсэл бол мөнхийн ач холбогдолтой юм. Бид өргөн дэлгэрсэн ёс заншлаар, эсвэл улс төрийн бодлогоор биш, харин Бурханы зарлигууд, Түүний үйлчлэгчдийн сургаалуудаар удирдагдах хэрэгтэй. Энэ бол энэхүү чухал шууд нэвтрүүлэгт оролцож байгаа Сүмийн бүх насанд хүрэгчдэд хандсан гол захиас, гол зорилго юм.

Ахлагч Холланд

Энэ бүхний мөнхийн төлөвлөгөөний талаар санал зөвлөмж байна уу эгч нар аа, яагаад бид зөвхөн нийгмийн хэрэгцээг хангадаг нэг байгууллага ч юм уу, агентлаг байдаггүй юм бэ?

Гурван төрлийн үүрэг амлалт

Таннер эгч

Гэрлэлтийг амлалт бүхий үүрэг хэмээн дэлхий үздэг гэж би боддоггүй. Харин бид гэрлэлтийг гурван талт амлалт хүлээсэн үүрэг гэж үздэг. Эхнэр нөхрүүд бие биедээ бас Тэнгэр дэх Эцэгтэй үүрэг хүлээдэг. Энэхүү гэрлэлтийг нэгтгэгч хүч нь энэрэл, Христийн цэвэр хайр юм. Энэрэл зөвхөн биднийг бие биед нь ойртуулдаг төдийгүй, бас Тэнгэр дэх Эцэгт маань биднийг ойртуулдаг, иймээс гэрлэлтийн харилцаанд бие биедээ илүү ойр дотно байдаг

Ахлагч Холланд

Та гараараа зурчих энэхүү гурвалжин дотор, тэнгэрийг гэр орондоо авчрах, Бурханыг гэрлэлтдээ авчрахыг хичээхэд бид онцгой анхаарах ёстой. Үүнийг хэрэгжүүлэхээр хичээж байгаа хүмүүст өгөх зөвлөгөө байна уу?

Лант эгч

Бид мөнхийн гэр бүлийн тухай ярьж байгаа нь төгс гэр бүлийн тухай биш юм, гэвч эцсийн эцэст төгс болохыг хичээж байгаа гэр бүл Тэнгэр дэх Эцэгтэй эргэж очих болно. Тэнгэрлэг Эцэг болон амьдралын сорилтуудаар дамжуулан ажиллаж бидэнд тусалдаг сүнсийг

оролцуулсан гурвалжингийн тухай санаа нь миний хувьд энэ амьдрал дах төгс гэр бүл юм. Ийм гэр бүлд сорилтууд тохиолддог, гэвч гэр бүлийн гишүүд Тэнгэр дэх Эцгийнхээ тусламжтайгаар эдгээрийг шийдвэрлэхийг хичээдэг.

Бэж эгч

Аль нэг шалтгаанаар нөхөртөө хаягдаж ганцаар үлдсэн эсвэл бэлэвсэрсэн эмэгтэйчүүдийн тухай би зарим нэг зүйлийг ярьмаар байна. Лацдан холбуулах үедээ итгэлээрээ төгс, төлөвлөгөөнд бат итгэлтэй байсан олон эмэгтэйчүүд одоо ганцаараа байна. Итгэлтэй эдгээр эмэгтэйчүүдээс олон нь, “Төлөвлөгөөнд би баттай итгэдэг, би ганцаараа учраас одоо энэ нь надад хамаагүй гэж хэлэхгүй” гэдэг. Би гэр бүлийн залбирлаа хийж, гэр бүлээрээ судар судалж, гэр бүлийн үдшээ хийсэн хэвээр байгаа. Энэ гэр бүлийг бид гэгээрүүлж, Их Эзэний төлөвлөгөөний дагуу хэрэгцээнд нь анхаарал тавих болно. Эдгээр зоригт эмэгтэйчүүдийг би магтаж, хүндлэн дээдэлдэг. Ганцаардлын улмаас тэд төлөвлөгөөг орхиогүй. Ганцаараа байх нь хэцүү, гэвч та үүнийг хийж чадна.

Ахлагч Өүкс

Энэ нь амар хялбар байна гэж Их Эзэн хэлээгүй, гэвч энэ нь боломжтойг тэр бидэнд итгүүлсэн билээ.

Гэр бүлийн үндэс

Бэж эгч

Бүтээгчийн төлөвлөгөөнд гэр бүл чухал байр эзэлдгийг бид яаж мэддэг вэ? Мөнхийн гэр бүлийн хэсэг байх

онцгой боломжийн төлөө бид мөнх бус байдлын өмнөх дэлхийд их том сөргөлдөөнд оролцсоныг илчлэлт харуулдаг.

Мөнхийн гэр бүлийн нэгж нь уг төлөвлөгөө бүхэлдээ юм. Бусад бүх юм уг төлөвлөгөөнд хамрагддаг.

Ахлагч Холланд

Тэнгэрт тойргууд, гадаснууд, эсвэл бидний мэдэхгүй өөр бусад байгууллага байж болно. Харин тэнгэрт гэр бүлүүд байдгийг бид мэднэ. Дараагийн амьдрал, тэрчлэн селестиеп амьдралын тухай илчлэгдсэн зүйлс нь гэр бүл дээр анхаарал төвлөрүүлдэг бөгөөд энэ бол ариун сүмийн болон ариун сүмийн гэрээ-нүүдийн өргөмжлөгдсөн зарчим мөн.

Үүний тухай бид яагаад ингэж их ярьдгийг ойлгоход нь Сүмийн гишүүд, гишүүн бус хүмүүст энэ нь тусална гэдэгт бид найддаг.

Ахлагч Өүкс

Мөнх бус байдал дараагийн амьдралд ямар ч хэрэггүй хүч, алдар нэр, өмч хөрөнгө, нэр хүнд гэх мэт олон зүйлд бид анхаардаг. Харин гэр бүл тийм биш.

Гэрлэлтэн дэх нийцтэй бөгөөд эв нэгдэлтэй байдал

Ахлагч Холланд

Үр хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлэх, хайрлах, тэд ямар хүн болох хэрэгтэй вэ, тийм болоход нь туслах тухай бид ярилцаж байна. Гэвч, юуны түрүүнд, гэрлэлтэн дэх хувь хүний хүчин зүйлүүд юу вэ?



Хүүхдүүд ямар орчинд төрж, өсч хүмүүжихийг өөрсдийнхөө хүсдэг тийм орчныг заавал бүрдүүлэхийн тулд бид гэрлэлт дээрээ хэрхэн анхаардаг вэ?

Лант эгч

Гэр бүлтэй болоход бид хэрхэн бэлтгэх тухай та асуулаа. Аз жаргалтай байхын тулд нөхөр эхнэр хоёр сүнслэг суурьтай, гэр орон, гэр бүлдээ байлгах зүйлийн талаар зорилго, итгэл үнэмшлээрээ эв нэгдэлтэй байх ёстой.

Бэж эгч

Хамгийн энгийн заавруудын нэг нь Эхлэл номын 2-р бүлэгт байдаг. “Эр хүн эцэг эхээ орхин эхнэртэйгээ нэгдэн нийлж, ингээд тэд нэг болдог” гэж Их Эзэн энд өгүүлсэн байдаг. Энэ нь гэр бүлийн хосуудад гурван үүрэг ноогдуулдаг. Тэд эцэг эхээ буюу гэр орноо орхиж, хамтдаа нийлж, нэг болдог. Хэрэв тэд энэ 3 зарчим дээр ажиллах юм бол, тэд энэ харилцааг Их Эзэнд зориулан хөгжүүлж эхэлдэг.

Ахлагч Өүкс

Гэрлэж байгаа залуу хос ёслолын үеэр тахилын ширээн дээр ёслол үйлдсэнээр асуудлуудаа шийдэхийн тулд юуны өмнө эцэг эх, ах дүүс эсвэл найз нартаа биш, харин бие биедээ найдлага тавьж, бие биедээ туслах ёстой, учир нь тэдний эв нэгдэл Тэнгэрлэг Эцгийн хайрын тэргүүлэл, эрх мэдлийн дор, энэхүү гурвалжин дотор, зайлшгүй тулгарах гэрлэлтийн асуудлуудыг даван туулахад тэдэнд туслах болно.

Таннер эгч

Адам, Ева хоёрын анхны хайрын тухай эхлэлийн энэ түүхэнд Адам эхлээд бүтээгдэж, Их Эзэн түүнд үзэсгэлэнт дэлхийг өгсөн байдаг. Цэцэгс, амьтад болон энэхүү гайхамшигтай цэцэрлэгийг Тэр амьдрахаар бүтээсэн. Гэвч Адам өсч хөгжиж чадахгүй байсан юм. Тэрээр туслагчтай болох хүртлээ өсч хөгжиж чадахгүй байв. Сэтгэл санаа, сүнслэг байдал, бие махбод юм бүхэнд түүнд туслагч хэрэгтэй байлаа.

Энэ түүх нь сайн гэрлэлтийн харьцаа нь ямар байх ёстойг бидэнд өгүүлж байна. Бид нэг нэгэндээ тохирсон байх хэрэгтэй. Амьдралын туршид өсч дэвжихэд юу хэрэгтэй тухай бид бодох хэрэгтэй. Бид гэрлэлтдээ өөрсдийн, төрөлхийн шинж чанараа авчирдаг ба бидний хүн нэг бүрт гэрлэлтэд гүйцэтгэх үүрэг байдаг. Гэвч ханийн энэ харилцаанд бид амин хувиа хичээх ёсгүй бөгөөд нэг нэгэндээ туслах хэрэгтэй.

Ахлагч Холланд

Аминч үзэл бол гэрлэлтэд учирдаг хамгийн том сорилт гэж Ерөнхийлөгч Хинкли хэлэхийг би сонссон. “Минийх юу болж байна?” гэх биш, харин “Эхнэрт минь юу хэрэгтэй байгаа билээ?” гэж хэлдэг болоход хүч чармайлт тавих талаар Сүмд өгөх зөвлөгөө та бүгдэд байна уу?

Лант эгч

“Миний хэрэгцээ яаж хангагдаж байна вэ” гэдэг үг өнөө үед дэлхийд маш өргөн дэлгэрчээ.

Ахлагч Холланд

Тийм ээ, *хэрэгцээ* гэдэг их өргөн утгатай үг шүү.

Лант эгч

Хэрэв өөр хэн нэгний хэрэгцээний тухай бид боддог байх юм бол, бидний хэрэгцээ хангагдана. Бидний хэрэгцээ хангагдах хамгийн сайн арга зам бол өөр хэн нэгэнд анхаарал халамж тавих явдал мөн.

Таннер эгч

Би аз жаргалтай гэр бүлд өссөн хүн. Гэвч, “Аз жаргалтай гэрлэлтийг бий болгоход маш их ажиллагаа, байнгын хүчин зүтгэл шаардлагатай” гэж ээж минь надад дахин дахин хэлдэг байсныг би санадаг. Тэр тэдэнд аз жаргалтай гэр бүл байгаагүй гэж хэлсэн юм биш харин тэр ханийнхаа адислалын тухай, түүний хэрэгцээний тухай бодохгүйгээр та нэг ч өдрийг хэзээ ч өнгөрөөх ёсгүй гэсэн хэрэг.

Ханиа сонгох нь

Бж эгч

“Би арван хуруу тэгш ханийг эрж байна” гэж залуу насанд хүрэгчид хэлэхийг бид олонтаа сонсдог. Тийм арван хуруу тэгш хань нь үүрд тэдний найз байна гэж тэд боддог оос гэрлэлтээ хойшлуулдаг. Хэрэв тэд Их Эзэний адислалуудыг болон мөнхийн гэр бүлийг бий болгохыг эрэлхийлэх юм бол, тэд чухам юуг эрж хайх ёстой юм бэ?

Ахлагч Өүкс

Тэнгэрт урьдчилан бэлтгэсэн гэрлэх хүнээ хүлээх учиртай гэдгийг сонсохдоо би үргэлж эргэлздэг. Тийм тохиолдол байж болох л доо. Гэвч бидний олонх нь хайр сэтгэлтэй болсон, хамтдаа байж, мөнхийн гэр бүлийг бий болгох зорилгыг хамтдаа хэрэгжүүлэх, нэгэн адил төгс сайн хийгээд жишиг зарчмуудыг баримталдаг хүнийг эрж хайдаг шүү дээ. Ямар нэг зүйл толгойд чинь, “Энэ бол хань чинь шүү дээ” гэж хэлэхийг хүртэл хүлээх нь гэрлэлтийг хойшлуулж, заримдаа үүнийг бүр болиулдаг.

Ахлагч Холланд

“За тийм ээ, би гэрлэхээсээ өмнө сургуулиа төгсөх хэрэгтэй,” эсвэл “Надад ажил хэрэгтэй, эсвэл мөнгө буюу машин хэрэгтэй” гэх мэт тайлбаруудыг бид бүгд сонсдог шүү дээ. Нийгэмд иймэрхүү болзлуудыг бид сонсох нь улам ихэсч байна. Бүх зүйл байрандаа байхыг бид хүсдэг

Жеймс Төөрбер олон жилийн тэртээ хэлсэн хайрын тухай тодорхойлолтод би дуртай. “Хайр бол та

нарын хамтдаа туулдаг зүйл” гэж тэр хэлсэн юм.

Залуу насанд маань, бас саад бэрхшээл, золиослол дунд биднийг холбодог туршлагауудыг ганц бие залуу насанд хүрэгчид та нар одоо ч, бас арай илүү мөнгөтэй болж мэдэх өтөл насандаа ч алдах ёсгүй.

Ахлагч Өүкс

Тэнгэрлэг Эцэг биднээр хийлгэхийг хүсдэг зүйлүүдийг бид хийсэн үед Тэр биднийг адислах болно. Бид юм бүгдийг өөрсдөө хийх гэж оролдсоноороо, Түүнийг амлалтуудаа биелүүлэх боломжийг алдагдуулахгүй байцгаая.

Лант эгч

Мөн Сүмийн жишгүүдийг хангахгүй хүмүүстэй гэрлэхэд нь залуу хүмүүсийг урамшуулан дэмжихийг бид хүсдэггүй. Энэ бол, сайн мэдээний хувьд, мөн Их Эзэнд үйлчлэхийн хувьд нийцдэггүй хүмүүстэй гэрлэх ёсгүй гэсэн үг юм.

Айдастай бүү амьдар

Таннер эгч

Гэрлэж, гэр бүлтэй болох, итгэлтэй байж, сайн мэдээний төлөө золиослол хийх нь бүгд баяр баяса юм. Энэ нь жинхэнэ баяр баясгалант бидний амьдралд авчирдаг. Гэр бүл бол бидний хувьд агуу адислал юм.

Ахлагч Холланд

Олон улсын хэмжээнд болон дотоодод бидний эргэн тойронд айдас төрүүлэм зүйл олон байдаг. Ирээдүйдээ эргэлзсэн залуу насанд хүрэгчид, өсвөр үеийнхэн: “Би ер нь

гэрлэх хүртлээ амьд явах болов уу?” гэж хэлэхийг нь би сонсдог.

Энэ нь ямагт хэцүү байдаг л даа. Айх айдасгүй байсан нэг ч үе түүхэнд хэзээ ч байгаагүй. Чухам иймээс л сайн мэдээ бидэнд байгаа юм шүү дээ. Энэ Сүмд бид айдастай амьдарч болохгүй, тэгвэл юмс зохих ёсоороо байхгүй. Соёл иргэншилд хувь хүний айдас, эсвэл хамтын айдас байж болно. Бид зөвхөн сайн мэдээгээр амьдарч, итгэлээ ашиглан, залбирлууддаа хариу авч, цааш явах хэрэгтэй. Энэ бол үргэлж замнаж ирсэн зам.

Ахлагч Өүкс

“Төгс хайр [Их Эзэний] айдсыг хөөн зайлуулна” гэсэн судрыг иш татъя (1 Жон 4:18 мөн Моронай 8:16-ийг үз) .

Адил тэгш хамтрагчид

Ахлагч Өүкс

Гэрлэхийг бодож байгаа зарим залуу хүмүүс, “Хэрэв таны хийх зүйлүүдийн бас миний хийх юмсын жагсаалтыг бид гаргаж чадах юм бол, уг жагсаалтын дагуу, бид аз жаргалтайгаар гэрлэх болно” гэж зарим залуу хүмүүс ярихыг би сонссон. Энэ тухайд та ямар бодолтой байдаг вэ?

Бек эгч

Гэрлэлт бол жагсаалт биш. Жагсаалт өөрчлөгддөг

Таннер эгч

Зохиолч Жон Милтоны “Paradise Lost” хэмээх шүлгийн номонд Адам Еваг магтан, “Хайртай нэгдсэн нийлсэн түүний үгс, үйл хэргүүдээс өдөр

бүр мянга мянган магтууштай сайн үйлс ундрэн гардаг гэж хэлсэн байдаг. Хэрэв бидэнд үг болон үйлсээрээ хайраа хэрхэн үзүүлэх вэ хэмээн үргэлж боддог сайн сайхан магтууштай чанартай харь байдаг байсан бол ямар гайхалтай байх байсан бол.

Лант эгч

Гэрлэсэн хүмүүст хөдөлмөрийн хуваарь байх ёстой, учир нь та бүгдийг өөрөө хийж чадахгүй шүү дээ. Залуу хосуудын хувьд өнөөдөр хөдөлмөрийн энэ хуваарь нь миний анх гэрлэсэн үеийнхээс өөр байна. Манай гэр бүл дэх залуу хосууд—манай хүүхдүүд, тэдний эхнэр, нөхрүүд юмсыг бидний хийдэг байснаас өөрөөр хийдэг. Тэд бусдаар ажил хийлгэдэг. Тэд өөр байдлаар хамтран ажилладаг. Олон талаараа энэ нь бидний хийдэг байсан аргаас илүү сайн байдаг.

Ахлагч Холланд

Адил тэгш хамтрагчид байх тухай гэр бүлийн тунхагт өгүүлсэн байдаг. “Чи зөвхөн тэжээгч байх болно, харин би зөвхөн мөнгөний төлөө санаа тавигч байх болно” гэж бид хэлдэггүй шүү дээ. Өөрчлөлт хөдөлгөөн, ахиц дэвшил, тэнцвэр, бүрдүүлбэр байх болно, гэвч энэ бүгдэд бид хамтдаа байдаг, энэ бүхнийг бид хуваалцах ёстой

Тунхагт яг онож хэлсэн юм шиг надад санагддаг. Энэ нь: “Их Эзэн Есүс Христийн сургаалд үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ” гэсэн үгс юм.

Ахлагч Өүкс

Чухамдаа энэ бол,” өөрийн чинь нүдэнд дүнз байх атал өөр хэн нэгний нүднээс үртсийг авч хаяхаар бүү оролд “гэсэн Есүс Христийн сургаалын илэрхийлэл юм.

Хожмын Үеийн Гэгээнтний соёл боловсрол

Бек эгч

Зарим найзууд маань Сүмд хөрвөгдөх үед, тэдний зан заншил, гэр бүлд ийм эв нэгдэл, Христийнх шиг үлгэр жишээ байсангүй. Гэвч тэд Сүмд нэгдэж, Аврагчийн сургаалуудыг баяртайгаар хүлээн авсан билээ, тэгээд тэд гэрлэхдээ, “Манай гэр бүлийн ёс заншил ямархуу байх вэ? гэдэг байлаа. Хожмын үеийн Гэгээнтний ёс заншлыг нэн анхааралтай хүлээн авахаар тэд шийдсэн билээ. Тэд судруудыг судалж байв. Зөв гэдгийг нь өөрсдийнхөө мэдэх зүйлүүдийг нотлохын тулд гэр бүл нь ямар байх ёстойг заадаг сургаалуудыг судалж байв. Мөн тэд Христийнхтэй адил зарчмууд дээр гэр бүлийн амьдралаа хөгжүүлдэг байв. Аврагч юу заасан бэ? Бид бие биедээ яаж ханддаг вэ? Сайн харьцаа, нинжин сэтгэл, хүндлэл дээдлэлээр.

Гэр бүл олон жилийн туршид өсөн дэвждэг. Улс орныхоо ёс заншлыг тэд дагадаггүй. Тэд гэр орондоо сайн мэдээний ёс заншлыг баримталдаг.

Ахлагч Өүкс

Хожмын үеийн Гэгээнтний ёс заншил бол ажлын жагсаалт биш,



Ариун үүргээ биелүүлэхэд эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой.

харин гэр бүл болох үлэмж сайн үндэс суурь юм.

Лант эгч

Гэрлэлт бол хэний зөв бэ? гэдэгт биш, харин юу зөв бэ? гэдэгт байдгийг бид хүүхдүүдээ гэрлэхэд нь хэлсэн. Гэр бүл болж байгаа хос бүр өөр өөрийнхөө гэр орноос уламжлалуудыг авчирдаг, эдгээр уламжлалууд нэгдэн нийлсэн үед юу нь зөв болохыг шийдэхдээ сайн мэдээний зарчмуудаар тодорхойлох хэрэгтэй. Ингэсэн тохиолдолд энэ гэр бүл эцэг эхийнхээ гэр бүлээс илүү бат бөх байх болно.

Итгэлтэйгээр хүүхэд төрүүлж өсгөх нь

Ахлагч Холланд

Адам Ева хоёрын гаргасан шийдвэрийн тухай урьд өмнө нь өөр ямар ч хүний мэдэх боломжтой байснаас илүү ихийг бидэнд өгүүлдэг Мормоны Номын 2 Нифайн 2-р бүлэгт би маш их талархаж явдаг

Еденийн Цэцэрлэгт Адам Ева хоёрт хүүхэд төрөх боломжгүй байсан нь тов тодорхой юм. Дэлхийн ихэнх нь үүнийг мэддэггүй. Бидний хувьд энэ бол сургаалын тулгуур үзэл санаа, мөнхийн төлөвлөгөө, үүнд гэр бүл гол байр эзэлдэг тухай санаа юм.

Таннер эгч

Гэр бүлийн тунхаг бидэнд байгаа учраас бид маш их адислагдсан билээ. Бид энэхүү тунхагийг судартай адилтгаж болно. Учир нь энэ нь амьд бошиглогчид, төлөөлөгчдөөс ирсэн бөгөөд өсөн үржиж, дэлхийг дүүргэх тухай эхнэр, нөхрийн хувьд Адам Ева хоёрт өгсөн Бурханы зарлиг хүчин төгөлдөр хэвээр байгааг нотолсон юм.

Би залуу байхдаа гэрлэсэн анхныхаа жилүүдэд тэрхүү тушаалыг төлөөлөгчид, бошиглогчид иНдэр дээрээс зааж байсныг сонсож байснаа санадаг ба зөвлөгөөнд нь баярлан талархдаг байлаа. Бид гэрлэж, үр хүүхэдтэй болох, боловсролтой

болох гээд бүгдийг нэгэн зэрэг хийхийг тэд бидэнд заасан нь боломжгүй юм шиг санагдаж билээ. Ингэх нь боломжгүй юм шиг санагдаж магадгүй бөгөөд энэ нь яаж боломжтой байх вэ гэж зарим хүмүүс гайхаж байгаа гэдгийг би мэдэж байна.

Энэхүү өсөн үрж хэмээх зарлиг хүчин төгөлдөр байгаа тухай бодохдоо, энэ нь үнэн бөгөөд агуу итгэл, агуу зориг, мөн олонтаа агуу золиослол шаарддаг гэдгийг би мэддэг. Хувиараа илчлэлт хүлээн авахад Их Эзэнтэй нэгдэн нийлдэг байхыг биднээс шаарддаг, мөн уг зарлигийн талаар хувиараа илчлэлт хүлээн авдаг бусад хүмүүсийг бид шүүхгүй байхын тулд цэвэр ариун зүрх сэтгэлтэй байхыг шаарддаг.

Ахлагч Өүкс

Таннер эгчийн саяын хэлцэг зүйл үнэн, бас туйлын чухал юм. Хүүхэд төрүүлж өсгөх талаар дэлхийн баримталдаг зүйлүүдийг дагадаг Сүмийн гишүүдтэй болох аюул өнөөдөр бидэнд нүүрлээд байна. Ийм шийдвэрийг Их Эзэний амлалтууд, аз жаргалын агуу төлөвлөгөө, амьдралын зорилго дээр тулгуурлан, нэн чухал, мөнхийн үр дагавартай шийдвэрүүдийг Их Эзэнд хандан залбирч, итгэлээр гаргахын оронд телевиз, эсвэл тухайн салбарт мэргэшсэн гэх нэрд гарсан хүмүүс, тэр ч байтугай хөршүүдийнхээ шахалтаар бусад эх сурвалжуудыг тэд ашигладаг.

Бек эгч

Энэ бол итгэлийн асуудал гэж би боддог. Дэлхий даяар олон газарт

орон сууц хүрэлцэхгүй байна. Бүр амьдрах газар ч олж чадахгүй байхад та хань ижилтэй болоод, яаж хүүхэд төрүүлж өсгөх юм бэ? Бид хангалттай мөнгө, өмч хөрөнгөтэй байгаагаас хүүхдүүдтэй болдог юм биш. Бид итгэл бишрэлтэй учраас хүүхдүүдтэй болдог.

Аз жаргалын төлөвлөгөөний дагуу Их Эзэний адислалуудыг эрэлхийлэх нь гайхамшгуудыг бий болгох болно. Орон сууцаар дутагдаж байгаа ч гэсэн, арга зам нь олдох болно. Аравны нэгийг мөнгөөр төлдөг юм биш, Аравны нэгийг төлөх нь итгэлийн асуудал байдгийн адил та мөнгөөр хүүхдүүдтэй болж чадахгүй.

Ахлагч Өүкс

Бид Ерөнхий эрх мэдэлтнүүд, ерөнхий ажилтнууд учраас ерөнхий зарчмуудыг заадаг.

Таннер эгч

“Хэрэв бид итгэлээр амьдрах юм бол, зам нь нээгдэх болно” гэдгийг амьдрал дээр мэдэрсэн учраас энэ ишлэл надад таалагддаг. Бид хоёрыг анх гэрлэхэд, хадам аав нөхөрт минь адислал өгч, “Сайн мэдээний зарчмуудыг дага—мэдэх зүйлээ гэр бүлдээ зориулж, итгэлээр амьдар, тэгвэл зам нь нээгдэх болно, урьдаас харах аргагүй замууд та нарт одоо нээгдэх болно” гэж хэлж билээ.

Итгэлээр амьдрах гэдэг нь бодлоггүйгээр амьдрах гэсэн үг биш. Бид ухаалаг хэрсүү байж, шаргуу ажиллаж, золиослол хийх, хүсч мөрөөлдөг зарим зүйлийг тэвчиж амьдрах хүсэлтэй байх хэрэгтэй. Аавынх нь адислал бидний амьдралыг дүүргэсэн

гэдгийг нөхөр бид хоёр мэднэ. Урьдчилан харах аргагүй замууд бидэнд нээгдсэн. Итгэлээр амьдардаг хэний ч хувьд энэ бол үнэн зарчим гэдэгт би итгэдэг.

Лант эгч

Эцэг эх болох хүсэлтэй байх ёстой тухай та нөхөд ярилаа. Энэ нь шаргуу ажиллаж, бид хэн бэ? гэдгээ танигдуулах юуг ч гэсэн хийх хүсэлтэй байхыг шаарддаг учраас бид айх ёсгүй. Золиослол биднийг ямар хүмүүс вэ? гэдгийг харуулдаг. Үр хүүхэдтэй байх нь ямар их баяр баясгалантай байдаг тухай гэрчлэлээ хуваалцахыг би хүсч байна. Энэ бол зөвхөн Их Эзэний зарлиг төдийгүй, бас амлагдсан агуу адислалууд юм.

Ахлагч Өүкс

Дэлхийн өнцөг булан бүрт олон хүүхэдтэй байхыг эсэргүүцдэг тухай бид сонсож байна. Эсвэл та ердөө нэг л хүүхэдтэй байх нь хангалттай, харин нэгээс олон хүүхэдтэй байх нь тэнэг хэрэг эсвэл эх оронч бус хэрэг гэх нь бий. Сайн мэдээний эсрэг чиглэсэн үй олон санаа бодол дэлхийд байдаг. “Бүх зүйлд сөрөг тал байх нь зайлшгүй” гэж Эцэг Лихай хэлсэн байдаг. Зөв гэдгийг нь мэддэг зүйлүүдээ хийх бүрд хүмүүст мэдүүлж, тэдний магтаал сайшаалыг бид хүсэн хүлээх хэрэггүй, харин Бурхан та нарыг адисална.

Зүрхний хүслүүд

Бек эгч

Гэрлэсэн олон хос үр хүүхэдтэй болохыг хүсэвч, хүүхдүүдээр адислагддаггүй. Тэдний сорилт бол үр

хүүхэдгүй байгаа явдал, иймээс бид тэднийг сонсож, дэмжих хэрэгтэй. Хэрэв үр хүүхэдтэй болохыг хүсдэг ганц бие эгч нар болон хосууд зөв шударга байх юм бол, хүсэл нь талаар өнгөрөхгүй нь лавтай. Учир нь энэ бол Бурханаас соёрхсон хүсэл юм. Энэ нь тэдний мөн чанар бөгөөд тэнгэрт байхад нь илчлэгдсэн юм. Тэдний хүслийг Их Эзэн адислах болно.

Ахлагч Өүкс

Тэдний хүслийг эцсийн шүүлтэд харгалзан үзэх болно. “Бидний үйлс, зүрх сэтгэлийн хүслүүдийн дагуу Их Эзэн шүүх болно” хэмээн бидэнд өгүүлсэн С ба Г-ний 137 дахь хэсгийн 9-р шүлэг нь биднийг хамгийн ихээр тайтгаруулагч ишлэлүүдийн нэг юм.

Эхлээд гэр бүлүүд

Ахлагч Холланд

Дээрх зарлиг биелэгдсэн тухай, мөн хүүхэд төрүүлэх, тэднийг өсгөн хүмүүжүүлснээр мөнхийн өсөлт дэвшлийг үргэлжлүүлэх тухай ярилцацгаая. Их Эзэний зарлиг бол зөвхөн хүүхэд төрүүлэх биш, хүүхдийг аврахын тулд зөв шударгаар төлөвшүүлэх явдал учраас дээрх сэдвүүд хоорондоо холбоотой юм.

Ахлагч Өүкс

Бид энэ тухай ярилцахдаа, гэр бүлийг нэгдүгээрт тавина гэдэг нь юу гэсэн үг вэ? гэдгийг авч үзье. Бид ингэж ярьдаг, бас үүнд итгэдэг, гэвч энэ нь юу гэсэн үг вэ?

Нийл Максвеллын нэгэн зүйрлэлийг иш татахын тулд нүдний

шилийг тань ашигламаар байна. Бид нүдний шилнийхээ дотор талц ямар нэг юм бичээд харахад бичсэн зүйлийг харж болдог. Үүнтэй нэгэн адил гэр бүл нь цаг заваа, эсвэл тойрог үйл ажиллагаануудаа төлөвлөх шийдвэрээ хэрхэн гаргадгийг бид нүдний шилэндээ харахдаа бид шилнийхээ дотор талц, “Гэр бүлийг нэгдүгээрт тавь” гэж бичсэн байна.

Ахлагч Холланд

“Тэнгэрийн доорх бүх юмс цаг хугацаатай бөгөөд бүх юм тогтоогдсон цаг мөчтэй ажээ” гэсэн Номлогчийн Үгсийн хэсэгт би дуртай. Нэг өдөрт хязгаарлагдмал цаг хугацаа байдаг ч хэмжээ нь хүн болгоны хувьд ижил байдаг. Хэрэв бид эн тэргүүний зүйлүүд дээр ажиллах

юм бол, гэр бүлийг нэгдүгээрт тавьж, ингэснээр илүү сайн ажиллаж чадна.

Ахлагч Өүкс

Гэр бүлийг нэгдүгээрт тавих тухай бид ярихдаа, гэр бүлийн залбирал, гэр бүлийн үдэш, хүүхдүүдийн маань сүнслэг байдлын өсөлтөд мөнхийн үр дагавруудтай зүйлийг бий болгоход цаг гаргах санаануудын талаар бид бодох ёстой.

Гэр бүлийн загварууд

Ахлагч Холланд

Миний өмнө нь дурдсан *загвар* гэдэг үгийг дахин авч үзье. Гэр бүлээрээ судар судлах, гэр бүлийн залбирал, гэр бүлийн үдэш зэрэг зүйлүүд бидний тийм байх ёстой гэж үздэг

шиг төгс байдаггүй. Эдгээр зүйлүүдийн тухай хүн бүр ойлгодог юм шигээр бид ярьдаг. Гэвч тэд ойлгодоггүй. Эдгээр нь гэр бүлийн загварын нэг хэсэг болсон байх ёстой юм.

Таннер эгч

Бид эдгээрийг хэвшүүлэх гэж оролдохдоо зарим үед өөрсдийнхөө төгс бишийг мэдэрдэг, өөрсдийгөө төгс сайн гэж боддоггүй ч гэсэн, хүүхдүүд маань эдгээр зүйлийг үргэлжлүүлж байгааг харах нь бидний хувьд гайхамшигтай



Ахлагч Холланд

Бидний зарим үйл ажиллагаа тэдний амьдралд үнэхээр өөрчлөлтийг гаргасан.

Таннер эгч

Гэртээ сураагүй ямар нэг зүйлийг сүм дээр хэзээ ч сураагүй гэж нөхөр маань аавынхаа оршуулган дээр хэлж билээ. Энэ нь өнөр бүлийн эцэг эхдээ үзүүлсэн өндөр хүндэтгэл байлаа. Хүүхдүүд нь заримдаа аав ээжийнхээ орон дээр цугларч, аав нь унтлагын өрөөний хөшигийг буулгаж, дээр нь авралын төлөвлөгөөний схемийг зурдаг байж билээ. Тэрээр “Бид аав ээжийнхээ орон дээр цугтаа суугаад авралын төлөвлөгөөний тухай сурдаг байсан. Ингэхдээ бид зөвхөн сайн мэдээний үнэний талаар сурсан төдийгүй гэр бүлээрээ “Өнөөдөр баавгай гадуур байхгүй байна гэдэг тоглоом юмуу гэр бүлээрээ өөр тоглоом тоглодог байсан.” Гэр бүл ойр дотно эв нэгдэлтэй байхын тулд, хүүхдүүддээ зааж, дурсамжийг бий болгохын төлөө олон сайн зүйлийг хийдэг байлаа.

Ахлагч Өүкс

Хоол идэж байхдаа телевизор асаадаггүй дүрэм манай гэр бүлд байсан, учир нь энэ цаг бол хамт байж ярилцах цаг байв. “Өнөөдөр чи юу хийв?” “Төвөгтэй юм юу тохиолдов?” “Бид яаж тусалж болох вэ?” гээд л ярилцдагсан. Мэдээний нэвтрүүлэг анхаарал сарниулдаг болохоор ярьж болдоггүй байв. Тэгээд ч хоолны цагаар бид бүгд гэртээ байдаг байсан. Тухайн цаг



үеэсээ болоод бид өглөөний хоолны үеэр бүгдээрээ цуглаж чаддаггүй байв—гэвч аль нэг хоолны үеэр бүгдээрээ хамт ширээнд суудаг байв. Энэ нь манай гэрийнхэнд тун сайхан байдаг байлаа

Таннер эгч

Бид ч мөн адил хамтдаа ярилцдаг байсан. Ярилцах нь биднийг зөвхөн хамт байлгаж, мэдээлэл өгдөг төдийгүй, хөгжилтэй байлгадаг байсан. Та нар ч хамтдаа инээж, сэтгэл хөдөлгөм туршлагаа хуваалцаарай. Манай гэр бүлийн залбирлаа ихэвчлэн өглөөний цай, үдийн хоолон дээрээ хийдэг байсан, учир нь эдгээр хоолны үеэр бид хамт байдаг байлаа. Гэр бүлийн залбирал нь ярианы маань сэдвийг эхлүүлдэг байв. Заримдаа нөхөр маань мэс засал хийлгэсэн эмээгийн төлөө залбирах эсвэл газар хөдлөлтийн улмаас зовлон зүдгүүр эдэлж байгаа дэлхий дэх хэн нэгний төлөө тэр

залбирдаг байлаа. Ингэснээр бид нар хооллож байхдаа ярилцах сонирхолтой сэдэвтэй болдог байсан ба энэхүү хамтдаа өнгөрүүлдэг цаг хугацаа нь биднийг гэр бүлийн маань хувьд нэгтгэдэг байв.

Бек эгч

Би өнөр гэр бүлд өссөн. Өнөр гэр бүл гэдэг бол олон янзын санаа бодол, хийх ажил олон байна гэсэн үг. Аав ээж маань гэр бүлийн үдшийг хүүхдүүддээ заадаг цаг болгон долоо хоног бүр “Гэр бүлийн хайр” дууг дуулдаг байсан. Долоо хоног бүр энэ дууг дуулах нь надад ядаргаатай санагддаг байсан.

Ахлагч Өүкс

Заримдаа бид бие биендээ ууртай байлаа ч гэсэн энэ дууллыг дуулдаг.

Ахлагч Холланд

Тэгэхдээ бүр даалгавраар шүү дээ
Лант эгч

Заримдаа ээж маань хүртэл ийнхүү дуулдагсан.

Бек эгч

Гэхдээ энэ бол дуулах дадлага гэхээсээ илүүгээр итгэл байлаа. “За одоо, нээлтийн дуулал ‘Тэр бүлийн хайрыг’ дуулцгаая” гэж аав маань долоо хоног бүр хэлдэгсэн. Юм бүгдийг асууж шалгаадаг насан дээрээ “яагаад? Дууллын номонд зөндөө олон сайхан дуулал байна шүү дээ?” гэж би ааваасаа асуухадаав над руу ширүүхэн харж, “Чамайг энэ дууллыг сурахаар би чамд 2 дахь хичээлээ заана” гэж хэлдэг байв. 2 дахь хичээл гэдэг нь юу яриад байсныг би ойлгодоггүй байв. Бид тэр 2 дахь хичээлийг огт үзээгүй. Гэвч он жилүүд өнгөрөх тутам, бид бие биенээ хайрлаж сурсныг би хэлэх ёстой. Аав ээж маань юм бүгдийн тухай ярих гэж хичээдэггүй, гэр бүлийн хайраас эхлэх юм бол, заасан зүйл нь хүссэн үр дүнд хүрэх болно гэдгийг тэд мэддэг байсан юм.

“Бид өглөө бүр л гэр бүлээрээ судар судлах гэж хичээх юм, гэвч тэд анхаарахгүй, хэн нэгэн нь үргэлж уйлах юм” гэж зургаагаас доош насны 4 хүүхэдтэй нэг гайхамшигтай залуу эх надад хэлсэн юм. “Та хэр удаан хичээж байгаа юм бэ? гэж би түүнээс асуув. “Өдөр бүр арван минут судар унших зорилт тавьсан” гэж тэр хариулсан юм. Тэгэхэд нь би түүнийг тайвшруулахаар, “хүүхдүүдийнхээ насанд тохируулан 2 минут ч уншсан болно доо” гэж хэлж билээ. Тэрээр хүүхдүүдийнхээ насанд тохирсон загварыг ойлгосон юм. Хоёр настай хүү-

хэддээ судар уншихад нь туслахгүй харин Адам Ева хоёрын зургийг үзүүлэн ярилцаж эхэлж болох байсан. Гэвч тэр маш итгэлтэй байсан ба тийм ч учраас би түүнд хайртай байсан юм.

Хэдий тийм боловч хүүхдүүдийг жаахан байхад нь судар уншиж өгөх нь маш чухал гэдэгт би итгэдэг. Судрын хэллэг нь эцэг эхий нь хэл шиг танил болох хэрэгтэй.

Бусдыг шүүхгүй байх

Лант эгч

Бусдыг шүүх тухайд би ганцхан үг хэлмээр байна. Бид хүмүүсээс үргэлж дутагдлыг олж хардаг юм шиг санагддаг.

Хүүхдүүд маань бага байхад, манайх олуулаа, нөхөр маань бишоп байлаа. Би бямба гарагт өдөржингөө ажиллаад, ням гарагийн өглөө бүр хүүхдүүдээ сүмийн цуглаанд аваачдаг байсан юм. Сүмрүү тэднийг эрт



аваачихгүй бол, бид амждаггүй байв. Би хүүхдүүдээ цуглаан эхлэхээс өмнө сүм дээр аваачиж, бид хоёр дахь эгнээний голын вандан сандлыг тэр чигээр нь эзэлдэг байж билээ.

Нэг өдөр нэг эгч над руу бөхийж “Лант эгч ээ, хүүхдүүд маань танай хүүхдүүд шиг ийм сайн байсан бол, танд амар байгаа шиг надад бас амар байхсан, би ч бас өнөр гэр бүлтэй байх байхсан” гэж хэллээ.

Би уйлж гарлаа, цуглаан дуусан дуустал уйлсан. Нөхөр маань, “Яасан бэ? Яагаа вэ?” гэж асуух мэт над руу ширтэн харж байлаа. Энэ нь эвгүй байсан болохоор би бүр ч цухалдав.

Бид бие биенээ хатуу, шударга бусаар шүүх нь олонтаа байдаг. Бид бие биенийхээ нөхцөл байдлыг сайн ойлгодоггүй. Тиймээс бид бие биенээ л хайрлах ёстой.

Ахлагч Холланд

Энэхүү төгс сайн сургаалаас чанга барь. Сүмийн сургаалуудаар амьдрах нь ууланд авирах лугаа адил шаргуу тэвчээрийг шаарддаг. Заримдаа энэ нь гэр бүл болгонд өөр байдаг.

Хамт ажиллах нь

Ахлагч Өүкс

Гэр бүлийн тунхаг “аав нарыг гэр бүлээ тэргүүлэн удирд” хэмээсэн байдаг. Аавууд гэр бүлээ дуудаж, гэр бүлийн залбирал, гэр бүлийн үдшийг хийхэд анхаарах ёстой. Заримдаа ээжүүд гэр бүлийн үдшийг төлөвлөх нь аав нараас хавьгүй сайн байдаг. Гэвч Их Эзэн хариуцлагыг аав нарт өгсөн юм.

Иймээс “эцгүүд тэргүүлэх ёстой” гэж гэр бүлийн тунхагт бид уншдаг шүү дээ.

Ахлагч Холланд

Олон хүчин зүйл хүмүүсийг гэр орноос нь хөндийрүүлдэг талаар бид өмнө нь дурдсан. Энэ бол хүмүүсийг, ялангуяа аавуудыг гэр оронд нь байлгахыг бид хичээдгийн өөр нэг жишээ юм.

Лант эгч

Аавууд гэр бүлээ тэргүүлж, гэрийнхнээ удирддаг. Харин ээжүүд үүнд нь туслах хэрэгтэй. Аав ээжүүд гэр бүлээ цугларах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй. Тэгснээр тэдэнд замыг бэлтгэж өгдөг.

Бек эгч

Гэр бүл Бурханаас томилогддогийг та нар мэдсэнээрээ, энэ үүрэг хариуцлагыг хуваалцдаг, тиймээс хамтран төлөвлөж, төлөвлөснөө хэрэгжүүлэхэд анхаарч, үүнд тусал.

Лант эгч

Хүүхдүүд мөн өсвөр насныхан хүсэл эрмэлзэлтэй байх ёстой

Бек эгч

Зарим үед тэд хүсэл эрмэлзэлтэй байдаг л даа.

Ахлагч Өүкс

Энэ бол жижиг зүйл биш юм.

Лант эгч

Гэр бүл юун дээр тулгуурлах ёстойг эдгээр бүх зарчмууд бидэнд зааж өгдөг. Энэ бол ариун сүм юм. Манай гэр бүл ариун сүмд орсон уу, эсвэл ариун сүмд орохоор бэлтгэж байна уу, ялгаагүй. Ариун сүм бидний амьд-

ралд адислал байдаг. Үнэний болон гэр бүлийн амьдралын эдгээр зарчмууд ариун сүмтэй нягт холбоотой, бид энд мөнхийн гэр бүл болдог.

Үнэт эрдэнэ болсон хүүхдүүдийг итгэл хүлээлгэн өгсөн хүмүүст эрхэм ариун үүрэг ноогддог нь тодорхой юм. Учир нь бид бол өнөөгийн хүүхдүүдийг хайр, итгэлийн халуун илчээр, мөн тэд хэн бэ гэдгийг ойлгох ойлголтоор өсгөн хүмүүжүүлэхээр Бурханаас томилогдсон хүмүүс юм.

Өнөр гэр бүлүүд

Ахлагч Холланд

Бид яагаад гэр бүлүүдэд тусалж чадах өвөө эмээ, авга, нагац болон гэр бүлээсээ хол байгаа хүмүүсийн тухай ярьж болохгүй гэж. Төгс сайн болох зүйлүүд, тэрчлэн сургаалд бид бүгд нэгэн үзүүрт сэтгэлээр хандах учиртай. Гэр бүлүүдэд хүмүүсийн анхаарлыг хэрхэн хандуулж болох тухай санал байна уу?

Лант эгч

Эх хүний хувьд бусдаас тусалцаа аваагүй гэж бодохгүй. Хүүхдүүдэд минь нөлөөлж байдаг багш нар, хөршүүд, найз нөхөд, хамаатан садангууд зэрэг сайн хүмүүст би баярлан талархдаг. Хүүхдүүдэд минь хүмүүс олон арга замаар тусалдаг. Үүнд нь би их талархдаг. Энэ нь бидний хүүхдүүддээ заахаар хичээдэг зүйлүүд дээр нэмэлт гэрчлэл болдог. Зарим үед та хүүхдүүдийнхээ хэн нэгэнд нь нөлөөлж чадахгүй байхад, өөр хүн түүнд нөлөөлж чаддаг.

Хүүхдүүдийн маань зарим нь гадаадад амьдарч байна. Отгон охин маань нөхөртэйгөө хамт Испанид амьдардаг, тэр саяхан хүүхэдтэй болсон. Тэр бяцхан охин эмээгээсээ газрын мухарт гэмээр хол байгаа ч би түүний төлөө санаа зовдог ч гэсэн, гэр бүлд нь гайхамшигтай Гэгээнтнүүд байгаа болохоор юу алзахав. Охинд минь тусалж, бяцхан зээ охиныг минь халамжилж анхаарал тавьж, амьдралд нь тусалж байсны төлөө би тэдэнд маш их талархдаг.

Ахлагч Өүкс

Намайг найм ч хүрээгүй байхад аав маань өөд болсон. Аавгүй өссөн надад өвөө эмээ, авга, нагац, үеэлүүд минь тусалдаг байсан. Нэгдсэн Улсаас бусад оронд амьдардаг төрөл төрөгсдийнхөө хүчирхэг байгааг харах нь надад гайхалтай санагддаг. Түүнчлэн дэлхийн өнцөг булан бүрд байгаа өвөө эмээ, ач зээ нарыг хамарсан гэр бүлийн бүтэц нь Хойт Америкийнхаас илүү бат бөх байна.

Төрөл төрөгсдийг хамарсан гэр бүлийг бэхжүүлэхийн тулд тэдэнд хүрч ажиллахад би Хойд Америк дахь гишүүдийг урамшуулан дэмжиж байна.

Бек эгч

Бас тойрог бол нэг гэр бүл юм. Тойрог бүрд олон янзын туршлага, олон төрлийн сорилтууд байдаг. Зарим эмэгтэйчүүд үр хүүхэдтэй болж, зарим нь гэрлэж зарим нь бэлэвсрэх болно. Цөөхөн эмэгтэй-

чүүд бүр олон хүүхэдтэй болно. Ийм тойрогт бид өнөр өтгөн гэр бүлийг дэмжих ёстой. Өнөр өтгөн гэр бүлтэй болох нь хэцүү. “Дахиад хүүхэдтэй болно гэдэг чинь галзуурсан хэрэг” гэж Сүмийн гишүүн биш хүн хэлж болох ч бид баяр хүргэж, “Би таныг дэмжиж байна. Танд туслахын тулд би чадах бүхнээ хийе” гэж хэлэх хэрэгтэй.

Ахлагч Өүкс

Зарим Гэгээнтнүүд бусад Гэгээнтнүүдийг олон хүүхэдтэй гэж шүүмжилдэг гэдгийг бид сонссон. Эхнэр Жүүнийг маань тав дахь хүүхдээ тээж байхад нь манай тойргийн маш идэвхтэй нэг эгч, “Та нар юу л хийх гээд байна даа, дэлхийг танайх дангаараа дүүргэх нь үү?” гэж хэллээ. “Өөр хэн нэгэн үүнийг илүү сайн хийж чадна гэж би бодохгүй байна” гэж эхнэрийгээ хариулахад би түүгээрээ бахархсан.

Ахлагч Холланд

Эрүүл мэндийн болон материаллаг бус бусад асуудлууд байдгийг бид бүгд хүлээн зөвшөөрдөг. Бид мөнгөний асуудал эсвэл нийгмийн болон ёс заншлын дарамт шахалтуудын тухай биш сайн мэдээний үнэн зарчмуудын тухай ярьж байна. Энэ бол шүүхгүй байх шалтгаан юм. Бид заадаг, дэмждэг, хөгжөөн баясгадаг, сайн мэдээнд нийцүүлэн, хувь тавилангаа эрэлхийлэхэд нь хүмүүсийг урамшуулан дэмждэг.

Хэзээ ч битгий бууж өг

Таннер эгч

Хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх тухайд өөрсдийнхөө талаар тааруухан бодол дүгнэлттэй хүмүүс манай сонсогчдын дотор байгаа нь лавтай. Төгс сайн, бодит амьдралын хоорондын маш том ялгаа байгаа юм шиг бидэнд санагддаг. Гэвч эх буюу эцэг байх нь мөнхийн үүрэг, мөнхийн дуудлага бөгөөд аль нэг дуудлагатай байснаараа бид бурханлиг тусламжаар адислагддаг. Мөн хүүхэд өсгөн хүмүүжүүлэхэд энэ сүнс бидэнд хэрэгтэй байдаг. Елишагийн нэгэн адил, хүүхэд өсгөн хүмүүжүүлэхэд энэ сүнс бидэнд хоёр дахин их хэрэгтэй. Ийм сүнсээр бид адислагдсан билээ. Эд бол Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүд (Хаадын дэд 2:9) Тэнгэрлэг Эцэг биднийг хоёр дахин их адислах болно.

Ахлагч Өүкс

Зарим хүүхдүүд бусдаасаа илүү хэцүү байдаг. Эцэг эхийн анхаарал халамж тавих буюу зарим нэг чухал шийдвэр гаргахад бүх хүүхдүүдэд адилхан хандаж болохгүй. Өмч хөрөнгө хуваахад бид адил тэгш байж болно, харин хүүхдүүдийн хэрэгцээ өөр өөр байдаг учраас цаг хугацааг хуваарилах ёсгүй.

Бек эгч

Үүний жишээг би өөрийнхөө гэрт харсан. Арван хүүхдийн ууган нь болох эгч маань 2 настайдаа сонсголгүй болсон юм. “Энэ хүүхдэд би 10 минут, дараачийнхад нь бас 10 минутыг би зориулах болно” гэж

хэлж чаддаггүй байсан. Тэр охиныг халамжлахад ээж маань ихэнх цагаа зориулдаг байлаа.

Лацдан холбогдсон мөнхийн гэр бүл нь туслалцаа мөн хүчийг ариун сүмээс авдаг. Гадасны ерөнхийлөгч юм уу, бишопт тухайн гадас, тойргийг ажиллуулах эрх мэдлийг өгдөг шиг, хариултууд хүлээн авах, бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд илчлэлт хүлээн авах хүчийг эцэг эхчүүд ариун сүмд авдаг.

Ахлагч Өүкс

Эцэг эх хүүхдүүдийн хариуцлагыг ойлгохын нэг хэсэг нь Бурхан хүүхдүүддээ сонгох хүчийг өгснийг хүлээн зөвшөөрөх явдал мөн. Тэд сонголтлоор хийж, хариуцлага хүлээх насанд хүрсэн хойно нь ирдэг. Хүүхдүүдийнхээ гаргасан үйлдлийн гэм бурууг эцэг эхчүүд үүрдэг нь харамсалтай юм.

Бид хэзээ ч бууж өгөх учиргүй. Бид зөв зарчмуудыг зааж, бүхнийг хайр, итгэл сүсэг бишрэлээр заах үүрэгтэй. Энэ бол гэр бүлүүд, Сүмийн эрх мэдлийн хувьд баримтлах санваарын зарчмууд юм. Байнга залбирч хичээснээр гэм буруугийн хүнд ачаа дарамтыг зайлуул. Хүмүүс буруу сонголт хийж болно, заримдаа үүнийг мэдэх цорын ганц арга зам нь сонголт хийж, үр дагавруудыг нь харах явдал юм. Ингэснээр бид Их Эзэн Аврагч Есүс Христийн Цагаатгалын зүйрлэшгүй хүчинд итгэл найдвар тавьдаг. Их Эзэний Цагаатгалын хүчээр дамжуулан уучлагдах боломжгүй маш цөөхөн нүглийг мөнх бус байдалд бид үйлддэг.

Уур амьсгалыг зөөллөх нь

Лант эгч

Бие биенээ хайрлах тухай бид хангалттай ярьдаг биз дээ? Яаж заах ёстойг, юу хийх хэрэгтэйг ярилаа. Бид бие биенээ хайрлах ёстой. Эцэг хүн хүүхдүүдийнхээ эхийг хайрлахаас илүү агуу юуг ч тэдний төлөө хийж чадахгүй гэж би сонссож байсан. Хайраа харуулах арга замуудыг эрж хайх нь гэр бүлийн гишүүн бүрийн хувьд адилхан юм.

Ахлагч Холланд

Иймээс аав ээж хоёрыг аль болох их цагийг гэр орондоо өнгөрүүлэхийг Сүмийн хэмжээнд уриалж байна.

Хадам аав маань саяхан талийгаач болж, эхнэр минь уй гашууд автсан. “Аав маань надад мөн ч их хайртай байсан даа. Тэрээр орой болгон намайг хөнжлөөр хучиж дуулж өгдөг байсныг би санаж байна” гэж тэр хэлж билээ. Аавууд гэртээ байх нь их чухал. Хүүхдийнхээ живхийг надаас дээр сольдог, тэднийг сүм рүү авч явдаг хүүгээрээ би бахархдаг.

Лант эгч

Дэлхийн сөрөг нөлөө нь чухал асуудлууд болон гэр орноос маань биднийг хөндийрүүлэхийг хичээж байна. Зарим үед хэтэрхий их өмч хөрөнгөтэй байх эсвэл огт хөрөнгөгүй байх нь биднийг гэр бүлээс хөндийрүүлдэг. Энэ бүхэн материаллаг зүйлүүдтэй холбоотой. Эн тэргүүнд анхаарах зүйлүүдээ нухацтайгаар авч үзэх хэрэгтэй. Бид зав чөлөөгүй байна уу? Бид хэрээсээ

хэтэрсэн их ажилтай байна уу?

Хүүхдүүдийн маань амьдралд өөрчлөлт гаргадаг зүйлүүдийг бид анхааралтай авч үзэн, сүнслэг зүйлүүдийг эрэлхийлэх хэрэгтэй.

Бек эгч

Их Эзэний төлөвлөгөөг дагахад илүү үйлдэл, нэмэлт цаг хугацаа шаарддаггүй. Үүнийг энгийн аргаар хийж болно. Хамгийн чухал нь зохих уур амьсгалыг бүрдүүлэх явдал мөн. Юмсыг бид хариуцлага, амжилт жагсаалтаар хэмжих нь олонтаа байдаг. Гэвч *тэжээн тэтгэх* гэдэг үг өсөхөд нь туслах гэсэн утгатай юм. Ямар ч үр хуурай, хүйтэн эсвэл хатуу газарт ургадаггүй. Эцэг эхийн үүрэг нь итгэл, найдвар, энэрэлтэй сүнсээр өсч хөгжих газрыг бүрдүүлэхэд оршино.

Мексикт нэгэн жижигхэн гэрт гайхамшигтай нэг эхийг би харсан. Түүнд цэцэрлэг байсангүй, харин тэр жижигхэн хашаатай байв, тэгээд цэцэг, мод, усан оргилууртай цэцэрлэгийг ханан дээрээ зурсан байлаа. Гэр бүлийнхээ өсч хөгжих уур амьсгалыг

бүрдүүлэхийг тэрээр хичээсэн нь энэ ажээ. Гэр бүлдээ зориулж таатай нөхцөлийг бий болгосон нь хичнээн сайхан санаа билээ.

Ахлагч Өүкс

“Хүүхдүүдээ би бүх зүрх сэтгэлээрээ хайрладаг, гэвч би тэднийг үргэлж хайрлаж чадахгүй” гэсэн Пөөрл Баккийн үгсэд ээж минь дуртай байлаа. Гэр бүлээ тэжээгчийн хувьд түүнд байгаа багахан цагт тэр ухаалаг ханддаг байсан. Хамт байх ховорхон тохиолддог мөчид бидний юу хийж байгааг ээж минь анхааралтай хардаг байсан. Ээж бидэнтэй



хамт ажиллахад дуртай байлаа. Гараж цэвэрлэхэд ээж биднийг зохион байгуулдаг байсан санагдана. Энэ тухай эргээд бодоход, хүүхдүүдээ эцэг эхтэй нь хамт ажиллуулах замаар ээж минь эцэг эхийн байхын чухал үүргээ биелүүлж байсныг би тэр үеэс илүүтэйгээр ухаардаг.

Зарим хотод эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ хамт байх нь хэцүү.

Эхнэр, нөхөр, хүүхдүүд бүгдээрээ талбайд хамт ажиллах боломжтой газарт ийм зовлон байдаггүй. Гэвч зарчим нь хаана ч адилхан, энэ нь бидний хувьд маш чухал юм.

Гэр бүлийг зохион байгуулах зарчмууд

Лант эгч

Дэлхий даяар гэр бүлүүд, гэр бүлийн нөхцөлүүд өөр өөр учраас бид зарчмуудын тухай ярилцах ёстой. Хүүхдүүдээ хэрхэн өсгөн хүмүүжүүлэх болон харилцаагаа яаж төлөвшүүлэхийг мэдэхийн тулд Сайн мэдээний үндсэн зарчмууд болох хайр, амин хувиа үл хичээх үзэл, уучлал, үйлчлэлээр амьдрах ёстой.

Ахлагч Өүкс

“Тэнгэрийн загвараар эцэг нь өрх гэрээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, амьдралын хэрэгцээт зүйлсээр нь хангаж, гэр бүлээ хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал мөн. Энэхүү ариун үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ

адил тэгш туслах ёстой” гэдэг эдгээр зарчмуудыг гэр бүлийн тунхаг бидэнд сануулдаг нь *санамсаргүй тохиолдол* биш юм.

Зарим тохиолдолд эх нь гэр бүлээ тэжээгч байж болно. Би ийм гэр бүлд өссөн. Аав маань өвчтэй байсан. Гэвч эрх тэгш хамтрагчдын зарчмаар асуудлуудыг шийдвэрлэхэд, нөхцөл байдал нь тэнгэрийн сүнслэг нөлөөгөөр шийдвэрлэгдэж болно

Таннер эгч

Гэр бүлийг зохион байгуулахад бидэнд тодорхой зарчим, ур чадварууд хэрэгтэй. Ур чадвар дутагдах нь жинхэнээсээ гэр оронгүй байхын нэр биш гэр оронгүй мэт сэтгэлгээг бий болгодог. Би зөвхөн хоол хийх тухай яриагүй байна. Сүнс, тайван байдал мөн бидний яриад байгаа зарчмууд байдаггүй гэр оронтой хүн, жинхэнэ орон гэргүй хүмүүст тохиолддог шиг сэтгэл санааны гутрал, мансууруулах бодис хэрэглэх эсвэл ёс суртахуунгүй хэрэг явдалд орооцолддог. Эцэг эхчүүдийн хувьд бидэнд хамтран ажиллаж, гэр орноо төвхнүүлэн, гэр орныг зөвхөн амьдрах газар биш, харин сүнслэг мэдрэмж оршдог орчин болгох боломж байдаг.

Ахлагч Өүкс

Гэр бүлийг зохион байгуулах тухай ярьж байгаадаа би баяртай байна. Учир нь *гэр бүлийг зохион байгуулах* гэдэг үгийг зарим хүмүүс үл ойшоодог. Энэ нь зөвхөн хоол унд, цэвэрлэгээ хийх биш юм. Энэ бол мөнх амьдралын төлөө хүүхдүүдээ өсгөн хүмүүжүүлэхэд

шаардлагатай орчныг бүрдүүлэх явдал мөн. Энэ бол эцгийн мөн эхийн үүрэг юм

Лант эгч

Гэр орон бол гэр бүлийн бүх гишүүд ирж, бусдаар хайрлуулан, аюулаас хамгаалагдсан найдвартай газар байх хэрэгтэй.

Ахлагч Өүкс

Ажил үүргийн хуваарийн тухайд гэвэл, гэр орны ажил, гэр бүлээ зохион байгуулахын хоорондох ялгааг тодорхой болгоё. Гэр орны ажлыг хүн хүнд хариуцуулж болно, харин гэр бүлийг зохион байгуулахыг хэн нэгэнд хариуцуулж болохгүй. Гэр бүлийн үдэш явуулахыг бид хэн нэгэнд хариуцуулдаггүй шүү дээ. Гэр бүлийн залбирлыг, эсвэл хүүхдүүдээ хайрлах эх эцгийн хайрыг, эсвэл өсөлт хөгжилтөд чинь нөлөөлөх цаг хугацааг бид хэн нэгэнд хариуцуулдаггүй биз дээ.

Лант эгч

Эдгээр үүргүүдийг бид хэн нэгэнд даатгах биш харин хуваалцаж болно.

Ахлагч Өүкс

Тийм ээ бид чадна.

Ахлагч Холланд

Та нар үүнийг нийгэм, хамт олонд ч тохоож болохгүй, та нар үүнийг бизнесийн байгууллагуудад ч хариуцуулж чадахгүй.

Ахлагч Өүкс

Бүр Сүмд ч тохоож болохгүй.

Ахлагч Холланд

Сүм гэр бүлд хэрхэн тусалж, адисалдаг тухай, мөн гэр бүлийн асуудал бол Сүм эсвэл өөр хэн

нэгэн шийдвэрлэж чадахгүй эсвэл шийдвэрлэж болохгүй зүйлсийн талаар ярилцацгаая.

Үйл ажиллагаануудыг товлох нь

Ахлагч Холланд

Сүмийн удирдагчдад гэр бүлүүдэд туслахад болон үйл ажиллагааг төлөвлөж жигд явуулахад нь бид ямар зөвлөгөө өгөх вэ? Тойрог, гадсуудад цаг хугацаа чухал асуудал байдаг.

Ахлагч Өүкс

Тойргийн зөвлөл болон гадасны зөвлөлийг тэргүүлдэг бишопууд болон гадасны ерөнхийлөгчид өө Сүмийн үйл ажиллагааны төлөвлөгөөг зохиохдоо хурал болон үйл ажиллагаануудаар хуанлигаа дүүргэхийн оронд эцэг эхэд гэр бүлдээ зориулахад нь цаг гаргаж байцгаая.

Ахлагч Холланд

Бид хувь хүмүүсийг адислахыг хүсдэг, гэвч бид гэр бүлийг хамгаалах ёстой.

Бек эгч

Олон жилийн өмнө би нэг бяцхан дүрэм гаргасныг хүн бүр хэрэглэж болох юм. Тойргийн буюу гадасны үйл ажиллагаа бидэнд хэрэгтэй, гэр бүлүүд болон хувь хүмүүсийг бэхжүүлдэг учраас зохион байгуулах нь сайн хэрэг. Сөрөг тал нь үйл ажиллагааг уламжлал болгон, бүр баяр ёслол мэт зохиодог. Бид сайн мэдээний загваруудын тухай ярихдаа хэрэгцээг нь мэддэг байх ёстой.

Ахлагч Өүкс

Сүмийн төлөвлөгөөнүүд гэр бүлийн талаар илүүтэй анхаарахын хамт ажлын өдрийн орой, амралтын өдрүүдэд хэт ачааллаар дарахгүй, гэр бүлийнхэн хамтдаа байхад саад болохгүй байх нь хамгийн чухал.

Бид гэр бүлд зориулан илүү их цаг гаргавал зурагт үзэх, ганцаараа спортын үйл ажиллагаанд оролцох болон нийгэм, хамт олны олон үйлчлэлүүдэд зориулан цагаа дэмий үрэхгүй байх нь эцэг эхчүүдийн үүрэг юм. Цуглаанууд болон үйл ажиллагаануудыг гэр бүлүүдэд илүү их цаг гаргаж болохын тулд зохицуулахыг хичээж байна. Үүнийг гэр бүлийн сайн сайхны төлөө хийж байгаа ба энэхүү нэмэлт цагийг зөвхөн гэр бүлдээ зориулах хэрэгтэй.

Лант эгч

Энэ нь хариуцлагыг гэр бүл дээр дахин төвлөрүүлж байгаа хэрэг тийм үү?

Ахлагч Өүкс

Тийм ээ.

Тойрог болон гэр бүлийн зөвлөгөөн

Бек эгч

Тойргийн зөвлөл буюу ерөнхийлөгчийн зөвлөл хуралдсан үед, “Байгуулагаа бид хүмүүсээр яаж дэмжүүлэх вэ?” эсвэл “Энд олон хүмүүс, их дэмжлэг бидэнд байна” гэж хэлэх нь зохимжгүй юм. Харин “бид гэр бүлийг яаж дэмжих вэ?” гэдэг асуултнаас ажлаа эхлэх ёстой. “Гэр бүлийг бид яаж дэмждэг вэ?”

Энд бидний хийдэг зүйлс өөр юуг ч биш харин гэр бүлийг дэмждэг зүйлүүдийн л үр дүнд харэгддаг.

Ахлагч Өүкс

Энэ бол тойргийн зөвлөлүүдийн хувьд нэн чухал сэдэв. Энд хүн бүр өөрийн үзэл бодолтой байдаг. Бишоп бол шийдвэр гаргагч, гэвч тэр бүх бүлгүүдийн саналыг сонсон, Сүмийн үйл ажиллагаанууд болон цуглаануудад ямар хугацаа төлөвлөхийг шийдэж тогтоон зохицуулалт хийдэг.

Ахлагч Холланд

Бид өмнө нь төлөвлөөгүй байсан ч гэсэн, ярилцлагаа түр завсарлаж, Сүмийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дунд бий болгохыг хүсдэг зүйлүүдээ үзүүлэх нь зүйтэй байхаа

Ахлагч Өүкс

Улс орон бүрт

Ахлагч Холланд

Улс орон бүрд бид хүндэтгэлтэйгээр, анхааралтайгаар бие биенээ сонсдог. Энэ бол тойргийн зөвлөлүүдийн ч эхнэр, нөхрүүдийн ч хийх ёстой зүйл. Энэ нь уламжлал, түүх, зарим хүмүүсийн болон зарим тогтсон ёс заншлын эсрэг байж болно. Эгч нарын үгийг сонсох нь тэдний уламжлалд нийцэхгүй байлаа ч, эдгээр эгч нар санваарыг хүндэлдэг байлаа ч, сайн мэдээний соёл давамгайлах ёстой. Энэ нь бие биенээ сонсох, хайрлах, хамтран ярилцах, шилдэг санаануудыг авах, залбирах, үүний үр дүнд илүү сайн гэр бүлүүдтэй, илүү сайн Сүмтэй болох



Тойргийн зөвлөл буюу ерөнхийлөгчийн зөвлөл хуралдахдаа “Бид гэр бүлийг хэрхэн дэмжиж чадах вэ?” хэмээн бодож үзэх хэрэгтэй.

боломжийг бидэнд олгоно гэдэгт бид найддаг.

Нөөц боломж болон хэрэгцээг хангах

Ахлагч Өүкс

2003 оны 1-р сарын Дэлхий дахины удирдагчдын сургалтын цуглаан дээр Ахлагч Том Перри нэгэн гайхамшигтай зарчмыг өгсөн юм. Түүний үгс өнөөдөр таван жилийн өмнөхөөс өнөөдөр илүү ач холбогдолтой байна. Тэрээр хэлэхдээ:

“Салбар буюу дүүрэг, тойрог буюу гадасыг төлөвшүүлэх нууц нь гишүүдээ, тэдний чадварыг мөн хэрэгцээг мэдэн, гишүүдийнхээ хэрэгцээн дээр тулгуурласан хөтөлбөр боловсруулах явдал мөн. . . Том байх нь илүү сайн байдаггүйг хийдэг бүх зүйлдээ анхаарч бай. Зөвхөн нэгжийнхээ хэмжээ, өсч хөгжсөн байдалд тохирсон хурдаар өсгөн хөгжүүл. Гишүүдийнхээ хүч чадлыг хамгаалж хадгал”.

Энэ зарчим нь цаг зав, нөөц боломжоо үр ашиггүй үрэхээс удирдагчдыг хамгаалдаг.

Лант эгч

Энэ зарчмыг тойргийн хавсралт байгууллагын удирдагчид хэрэгжүүлэх ёстой. Та нар хүүхдийн хэсгийн удирдагчийг дуудаж уулзахад тэрээр хүүхдийн хэсгийн хөтөлбөрийг хараад, “Эдгээр бүх зүйлийг би яаж хийх болж байна аа?” гэж боддог.

Тэгээд тэр эдгээр зүйлүүдийг хийхээр ажиллаж, дээр нь бас юу хийж болохыг эрж хайдаг. Хийж буй бүх зүйл маань гэр бүл дээр төвлөрсөн байх ёстой. Учир нь үүнээс илүү чухал ажил бидэнд байдаггүй. Заримдаа бид хөтөлбөрийг уншиж, хэрэгцээндээ тохируулан сонгож болно.

Ахлагч Холланд

Зарим үед дуудлагадаа хичээл зүтгэл гаргах нь ихийг хийхдээ бус, илүү их анхаарлаа төвлөрүүлэх, илүү

сайн дүгнэлт гаргах, чанарыг сайжруулах явдал байдаг гэж Ахлагч Скотт хэлжээ. (Харин ажлын хэмжээ нь их биш, багахан байж болно. Бага зүйлийг хийсэн ч гэсэн гэр бүлийг өргөн хүрээнд нухацтай авч үзэх нь чухал.)

Лант эгч

Хэтэрхий их ажил хийдэг ихэд чадварлаг хавсралт байгууллагуудын удирдагчид олон байдаг. Бид хөтөлбөр дээр биш, хүмүүс дээр анхаарлаа төвлөрүүлэх ёстой.

Мэргэн ухаан ба сайн шүүлт

Таннер эгч

Дуудлага өгөхөөсөө өмнө гэр бүлийн нөхцөл байдлыг нь анхаарч үздэг санваартны удирдагчдад би талархдаг. Дуудлагууд сүнсээр нөлөөлөгдсөн байдаг боловч бас мэргэн ухаан, зөв шийдвэрийг шаарддаг.

Ахлагч Өүкс

Зарим нэгжүүд цөөн тооны идэвхтэй гишүүдтэй байдаг. Тойргийнхоо 10 хүнд тус бүрд нь дөрөв буюу таван дуудлага өгөхгүй байхад удирдагчид анхаарах ёстой. Энэ бол бат бөх гэр бүл буюу хүчирхэг тойрогтой болох арга зам биш. Сүнсээр нөлөөлөгдсөн санваартны удирдагч зав чөлөө багатай эцэг эхчүүд олон дуудлагатай байх ёсгүйг ойлгодог байх ёстой.

2003 онд Ахлагч Перригийн заасан зарчмын шаардлагуудыг хангах хэмжээнд хүртэл хөтөлбөрийг багасгах хэрэгтэй.

Ахлагч Холланд

Түүнчлэн золиослол бол Есүс Христийн сайн мэдээний зарчим хэвээр байгааг бид ойлгодог. Бид гадас, тойрог, салбар болон гэр бүлийнхээ гишүүдийн төлөө золиослол хийдэг. Бидний хувьд хийхэд хэцүү зүйлүүдэд дуудагддаг. Бид гэр бүл болон сүмээ хамгаалахын тулд мөн гэр бүлийн нэгэн адил Сүмийг цэцэглэн хөгжүүлэхийн тулд зөв шийдвэрийг гаргах шаардлагатай байлаа.

Энэ бүхнийг хийхэд бидэнд мэргэн ухаан, зөв шийдвэр гаргах хэрэгтэй, харин бид энэ бүхнийг нэг дор хийж чадахгүй. Заримдаа өмнө нь хийж байсан бүх зүйлээ хийх шаардлагагүй байдаг. Гэвч чухал зүйлүүдийг хийснээрээ бид адислагдах болно.

Бек эгч

“Эдгээр зүйлүүдийг сонгоход ухаалаг бай” гэж Ахлагч Баллард сургажээ. Золиослолын тухай сургаал чухал юм. Аав ээж хоёр маань үйлчилж, ажиллан, дуудлагууддаа суралцаж байхыг харснаар би “Энэ бол гайхамшигтай сүм” гэж боддог болсон үед миний гэрчлэлийн эхлэл тавигдсан юм. Гэрчлэл маань надад заадаг байв. Би үйлчлэлээрээ өсч хөгжин, Их Эзэнд ойр дотно болсон. Гэр бүл буюу үйлчлэлийн аль нэгийг нь би сонгох ёстой гэж хэзээ ч хэлэхгүй. Түүний хаант улсыг байгуулахад туслахад бид шийдвэр төгс байх, гэр бүл бий болгох нь хоорондоо нягт холбоотой юм.

Хүндэтгэлийн баяр баясгалан

Ахлагч Холланд

Хүндэтгэлийн өдрийн баяр баяслыг мэдрэхийн тулд бид боломжтой бүхнийг хийх ёстой. Ням гарагийг бүрэн дүүрэн баяр баясалтайгаар өнгөрүүлэх, гэр бүлийн эв нэгдлийг сайжруулахаас илүү чухал ажил Сүмд байхгүй. Би хичнээн завгүй байлаа ч гэсэн, ням гарагт бүрэн дүүрэн баяр баясгалантай байдаг. Хуучин Гэрээн дэх эртний тунхаглалуудаас эхлээд Сургаал ба Гэрээг хүртэл Хүндэтгэлийн өдрийн баяр баясал, шүтэн бишрэхийн мөн чанарын тухай өгүүлсэн байдаг. Хүндэтгэлийн өдрийг хамт өнгөрүүлэхийн тулд илүү ихийг бид хийж чадна. Сайн мэдээгээр амьдрахын чухлыг гэр орондоо илүү их мэдрэхийн тулд зарим ажил үүргийн тоог багасгахаар зорьж байна.

Бек эгч

Хүндэтгэлийн өдрөөр хийдэг олон зүйлс маань биднийг завгүй болгон Сүмд очдог шалтгаанаас маань биднийг хөндийрүүлж байна. Бид гэрээнүүдээ шинэчлэхээр сүмд очдог. Хэрэв гэр бүлүүд үүнд бэлтгэж, Хүндэтгэлийн өдрийн туршлагауд дээрээ анхаарал төвлөрүүлэх юм бол, бидний гэр бүл адислагдаж их амжилт олох болно. Бид ариун ёслолоос хүртэхээр сүмд очдог. Энэ нь бидний сүмд очдог хоёрдугаар биш нэг дэх шалтгаан юм.

Заримдаа бидний завгүйгээс болоод хүүхдүүд маань энэ захиаснаас хоцордог. Энэ бол тэдэнд

бидний заах эн тэргүүний зүйл байх ёстой.

“Хамтдаа хооллоцгооё”

Ахлагч Холланд

Гэр бүлийг зохион байгуулах жинхэнэ зорилго нь энэ үгийн хамгийн сайн, хамгийн дээд утгаар бол, бид хоолны цагаар гэр бүлээрээ хамт ширээнд суухад хэрэгждэг гэдэгт би итгэдэг. Хамт хооллохоос илүүгээр гэр бүлийг нэгтгэдэг юу ч байхгүй гэж бараг бүх судлаачид хэлдэг.

Бек эгч

Иоханы Сайн мэдээний миний дуртай хэсэгт Аврагч Галилын Тэнгисийн орчимд шавь нараа цуглуулан нүүрсээр гал түлж, загас шараад “Нааш ир. Өглөөний хоолоо идэцгээ” гэж хэлдэг. Энэ нь гэр бүлээрээ хооллохыг дүрсэлдэг. Тэднийг зүгээр гүйж ирээд, идэхийг биш харин ирж, хооллохыг урьсан юм. Мөн уг сударт, “тэд цадсаны дараа” Тэгээд тэр Түүний хонинуудыг (Иохан 21:9-15) тэжээх тухай гайхалтай сургаалыг тэдэнд зааж эхэлдэг. Энд хамтдаа хооллох тухай өгүүлсэн байна. Тэрээр өөрийн хонинуудыг тэжээх тухай гайхамшигт сургаалыг айлдсан юм. Хэрэв тэрээр үүнийг бэлтгээгүй байсан бол энэ нь ямар байх байсан бол?

Тэрээр сургаалын нөхцөлийг бий болгосон нь хоолны цаг байлаа. Энэ бол зүгээр тохиолдлын хэрэг биш байсан гэж би боддог.

Сургаалаас барьж авах нь

Ахлагч Өүкс

Бидний ярилцсан бүх зүйлд, эцэг эх байх болон гэрлэлтийн талаар, түүнчлэн мөнхийн ач холбогдолтой бүх зүйлүүдэд удирдамж болгож дэлхийн үлгэр жишээг баримтлахаас зайлсхийх нь бидний хувьд туйлын чухал юм. 2 Коринт 6-р бүлэг Төлөөлөгч Паул сайн мэдээг хүлээн авсан хүмүүст: “Ул итгэгчдийн хамт нэг буулганд бүү ор. Зөвт байдал болон ёс бус нь яаж хамтрах билээ?” гэж зөвлөсөн байдаг. Бид эдгээр нэн чухал мөнхийн шийдвэрүүдийг гаргах гэж хичээхдээ дэлхийтэй нэгдэж, мөр зэрэгцэн зогсож болохгүйг тэрээр бидэнд сануулж байгаа нь энэ.

Ахлагч Холланд

Хэрэв бид Сүмийн сургаал биднийг дэлхийд ирэхээс өмнө Тэнгэр дэх Эцэг бидэнд өгсөн төлөвлөгөө болон зөвлөгөөг мөн сургаалыг чанд баримтлах юм бол бид залбиралуудаа хариуг аван үнэн зарчмууд дээр тулгуурлах болно.

Чимни Рок, Мартины Көүвийг туулсан эцэг эхчүүд, энэ Сүмийн түүхт бүх газруудад тархсан бяцхан булшнуудыг аль нэг хөтөлбөрт буюу олон нийтийн ямар нэг арга хэмжээнд зориулж үлдээгээгүй юм. Есүс Христийн сайн мэдээнд итгэх итгэл тэдэнд байсан учраас тэд үүнийг тэнд үлдээсэн юм. Энэ нь тэдний сэтгэлийн угт байсан юм. Энэ бол өөдсийн чинээхэн үрсээ нутаглуулсан ээжүүдийн цорын

ганц арга зам байсан бөгөөд, “Амлагдсан нутаг тэртээ хол байна. Тэр хөндийг бид амлагдсан нутгаа болгохоор зорьж явна” хэмээн тэд хэлдэг байжээ.

Энэ бол гэрээнүүд, сургаал, итгэл, илчлэлт, Сүнсний улмаас болсон хэмээн тэд хэлж магадгүй юм. Хэрэв бид эдгээр бүгдийг гэр бүлүүддээ, Сүм дээр сахих юм бол, бусад олон зүйлүүд аяндаа ирэх болно. Бусад олон зүйлүүд бидэнд чухал байхаа болих болно. Гар тэргээр их юм авч явж чадахгүй. Манай анхдагчууд шиг тэд авч явах юмаа сонгох шаардлагатай байсан. “Бид энэ гар тэргэн дээр юу авч явж болох вэ?” гэдгийг шийдэхийг 21-р зуун биднээс шаардах

болно. Энэ нь биднийг хэн гэдгийг тодорхойлдог. Хэрэв бид илчлэлтүүдийг дагавал гэр бүлийг бас Сүмийг адислах болно.

Ахлагч Өүкс

Энэ бол төгсгөхөд сайн сэдэв гэж би бодож байна, Ахлагч Холланд аа.

Ахлагч Холланд

Ахлагч Өүкс, Бек эгч, Лант эгч, Таннер эгч та нартаа Сүмийн нэрийн өмнөөс талархаж байна. Та бүгдийн цаг, хайр, үйлчлэл, өөрсдийн чинь хийсэн золиослолууд, Есүс Христийн сайн мэдээн дэх гэр бүлийн хайр мөн гэр бүлийн амьдралын тухай таны итгэл үнэмшлүүдэд чинь баярлалаа. Маш их баярлалаа. Ах эгч нар аа та бүгдэд ч бас их баярлалаа.

Хамт хооллохоос илүүгээр гэр бүлийг нэгтгэдэг зүйл өөр юу ч байхгүй.



ТЭМДЭГЛЭЛ

1. "The Family: A Proclamation to the World," *Ensign*, Nov. 1995, 102.
2. Gordon B. Hinckley, in Conference Report, Apr. 2003, 64; or *Ensign*, May 2003, 59; and Conference Report, Oct. 1997, 94; or *Ensign*, Nov. 1997, 69.
3. See "Thurber," *Life*, Mar. 14, 1960, 108.
4. John Milton, *Paradise Lost*, book 8, lines 601–02.
5. M. Russell Ballard, "Great Shall Be the Peace of Thy Children," *Ensign*, Apr. 1994, 60.
6. Пеарл С.Бүкийн "At Home in the World," *Marriage and Family Living*-г үзнэ үү, Feb. 1942, 2.
7. Л.Том Пеппри "Basic Unit Program," *First Worldwide Leadership Training Meeting*, Jan. 2003, 9.
8. See Richard G. Scott, "The Doctrinal Foundation of the Auxiliaries," *Worldwide Leadership Training Meeting*, Jan. 2004, 7–8.
9. See M. Russell Ballard, in Conference Report, Oct. 2006, 16–19; or *Ensign*, Nov. 2006, 17–20.

Дэлхий дээрх ариун газар

ЕРӨНХИЙЛӨГЧ ТОМАС С.МОНСОН

ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ



Өөрсдийнхөө гэрт тэнгэрлэг байдлыг авчрах нь

Миний хайрт ах эгч нар аа, энэ сүнслэг цуглааныг даруухнаар төгсгөж байна. Бидний бодлууд гэр болон гэр бүлдээ төвлөрдөг. Яагаад гэвэл “гэр бол бидний зөв зохистой амьдралын үндэс суурь мөн”¹ түүнийг өөр юу ч орлож чадахгүй.

Гэр бүлүүд өөр өөр байдаг гэдгийг бид мэднэ. Зарим нь аав, ээж, ах эгч нартай, харин зарим нь ганц

бие эцэг эх ба хүүхдүүд байдаг. Мөн зарим нь ганц бие ч байж болно.

Өмнө нь бид ямар ч гэр бүлд өсч торнисон байж болно. Гэвч бид энэхүү хурал дээр өгөгдсөн зарчмуудыг дагах юм бол Их Эзэнтэй ойр байж гэр бүлдээ улам ихээр тэнгэрлэг хүчийг авчрах болно.

Өнөөгийн бидний Ариун Газар хэмээн хүндэтгэн нэрлэсэн хот тосгодын шороон замаар Есүс алхаж байхдаа Өөрийн шавь нартаа үзэсгэлэнт Галилын тухай сургаалт зүйрлэлээр хүмүүсийн илүү амар ойлгох хэлээр ярьж заадаг байлаа. Тэр ойр ойрхон өөрийг нь сонсож хүлээн авдаг гэр бүлүүдээр очдог байв.

Тэр тунхаглахдаа: “Тэр . . . дотроо хуваагдвал оршин тогтнохгүй”² Матай 12:25). Хожим нь Тэр сэрэмжлүүлэн хэлэхдээ: “Болгоогтун, миний өргөө . . . будлианы өргөө бус”³ (С ба Г 132:8).

Дэлхий улам бүр замбараагүй байдал төөрөгдлөөр дүүрч байна. Бидний эргэн тойрон буй мэдээлэл

эрхэм хэмээн дагах бүхэнтэй маань зөрчилддөг. Хууран мэхэлж хууль бус аргаар эрхэндээ оруулан ноёрхож бидний “ёс суртахуунтай, сайн сайхан, хүндэтгэн бахархууштай” (Итгэлийн тунхаг 1:13) Есүс Христийн Сургаалаас холдуулан бодлыг минь эзэмдэхийг хүсч байна. Гэвч, бидний гэр бүл зорилгодоо нэгдмэл, амар амгалан хайраар дүүрэн уур амьсгалтай байваас дэлхийд буй найдвартай хоргодох газар болж чадна.

Бид ядарсан, өвчтэй болон шантарсан үедээ өөрийн гэр бүлээс хүссэн халуун дулаан бүхнийг хүлээн авбал ямар сайхан байх билээ. Бид энэ эвсэг гэр бүлийн гишүүн болж төрсөндөө баяртай байдаг.

Заримдаа бид гэр бүлээсээ, орон гэрээсээ уйдах эсвэл уурлах мөн үүнтэй төстэй янз бүрийн байдалд орж магадгүй. Эдгээр нь дандаа л нэг ижил хэвийн сэтгэл татам бус санагдаж бусад газрууд илүү сэтгэл хөдөлгөм сайхан байгаа мэт санагдаж болно. Гэвч бид дэлхийн юмс ямар өнгөцхөн хуурамч гэдгийг мэдрэх бүрт ухаажиж, туршлагажин өөрсдийн гэр бүл, гэр орон болон ойр дотны хүмүүсийн найдвар түшигтэй байдалд найдаж болох боломжиндоо талархах сэтгэл улам ихээр өсөн хөгждөг. Бид үүрэг хариуцлагаа хамтран биелүүлэх, хүндэтгэлтэй байх, нийтлэг байх гэдэг нь ямар учиртай болохыг ойлгодог. Бидний адислагдсан гэр бүлийн амьдралын харьцаа мөн



Өдөр бүр бид гэр бүлээрээ хамтдаа залбирснаар өнөөгийн дэлхийгээс биднийг хамгаалах зайлшгүй хэрэгтэй тэдгээр хамгаалалтуудыг олж авдаг.

түүний бүрэн бүтэн байдлыг өөр юу ч орлож чадахгүй.

Бид бүгдээрээ хүүхэд ахуйн орон гэрээ үргэлж дурсан санадаг. Бидний ихэнх нь байшин маань том байсан уу жижиг байсан уу гэдгийг, хөрш маань баян байсан уу ядуу байсан уу гэдгийг санадаггүй. Харин бид гэр бүлдээ тохиолдож байсан зүйлсийг л тод санадаг

Маргерет Тетчер, Их Британийн Ерөнхий Сайд байхдаа өөрийн бодлоо илэрхийлэхдээ: “Тэр бүл нь нийгмийг бүрдүүлэгч үндсэн нэгж мөн. Энэ нь асрах газар, сургууль, эмнэлэг, амралтын төв юм. Энэ нь нийгмийг бүхэлд нь тодорхойлон төлөөлж байдаг. Тэр бидний итгэл үнэмшлийг нэмэгдүүлж, энэ нь бас бидний амьдралдаа бэлтгэгдэх газар.”⁴

Би бидний орон гэр маань “аз жаргалын өргөө” мэт баталгаатай байх гурван зарчмыг санал болгохыг хүсч байна.

Залбирлын загвар

Нэгдүгээрт: Тогтмол залбирч хэвш.

Хүмүүсийн бодлоор хуучин юм шиг санагддаг гэр бүлийн залбирлыг бид одоо ч хийж байгаа нь талархууштай хэрэг биш гэж үү. Гэр бүлээрээ хамтдаа залбирал хийж байгаа зураглалаас илүү үзэсгэлэнтэй дүрслэл дэлхий дээр үгүй билээ. Их Эзэн бидэнд гэр бүлийн залбирал хийх чигийг өгч хэлэхдээ: “Эхнэрүүд хийгээд хүүхдүүд чинь адислагдаж болохын тулд гэр бүлээрээ Тэнгэрлэг Эцэгт хандан Миний

нэрээр үргэлж залбир” гэжээ (3 Нифай 18:21).

Өдөр бүр бид гэр бүлээрээ хамтдаа залбирснаар өнөөгийн дэлхийгээс биднийг хамгаалах зайлшгүй хэрэгтэй тэдгээр хамгаалалтуудыг олж авдаг.

Суралцах номын сан

Хоёрдугаарт: Бидний гэр нь суралцах номын сан байг.

Суралцах номын сангийн чухал хэсэг бол сайн номнууд. Унших гэдэг нь энэ амьдралаас авах таашаалуудын нэг юм. Одоо үед бидэнд хураангуйлан, хялбарчилсан, хуурамч болгосон ном л олддог бөгөөд энэ их зөрчилдөөн дунд ганцаараа сууж сайхан ном унших нь бидэнд тайвшрал амар амгаланг авчирч бодол санааг маань төлөвшүүлдэг.

Нэрт зохиолч Жэймс А.Мичэнэр хэлэхдээ: “Үндэстэн ямар байх нь залуучуудын юу уншснаас шалтгаалдаг бас хүмүүсийн хүсэл зорилго нь багаасаа тодорхойлогдож төлөвшдөг.”

Их Эзэн хэлэхдээ: “. . . Мэргэн ухааны үгсийг шилдэг номнуудаас эрэлхийлэгтүн та нар, бүр судлахаар мөн тэрчлэн итгэлээр, суралцахыг эрэлхийлэгтүн.” (С ба Г 88:118).

Мэдээж, судрууд маань бидний суралцах хамгийн сайн ном юм. Тэдгээрээс тогтмол уншицгаая. Ганцаараа болон гэр бүлээрээ хамтдаа суралцацгаая. Тэгснээрээ бид Их Эзэнтэй ойр байж сурч гэгээрэх болно.

Хайрын өв

Гуравдугаарт: Хайрын өв уламжлалаараа бахархацгаая.

Хайрын жижиг үлгэр жишээ бол бяцхан хүүхдүүд чимээгүйхнээр өөрсдийн эцэг эхээ харан суралцдаг. Тиймээс бүгдээрээ зөв зохистой үлгэр жишээг үзүүлцгээе. Бидний гэр бүл хайрын өвтэй байвал Мормоны Номонд бичсэнчлэн Иаковын шийтгэлийг хүлээн авахгүй: “Та нар цэвэр эмзэг эхнэрүүдийнхээ зүрхийг эмтэлж, мөн тэдний өмнө өөрсдийн муу жишээнүүдийн учир, хүүхдүүдийнхээ итгэлийг алдсан; мөн тэдний зүрхний мэгшилтүүд та нарын эсрэг Бурхан өөд дээш ирж байна. Мөн та нарын эсрэг доош ирэх Бурханы үг шулууны учир олон бодгаль гүнзгий шархнуудаас цоорч үхсэн билээ.”⁷ (Иаков 2:35).

Харин гэр бүл гэр орон маань хайраар дүүрэн байх болно. Бие биесээ хайрлая, сургаалыг хайрлая, найз нөхдөө хайрлая мөн Аврагчийн хайрлая. Ингэвээс тэнгэрлэг бүхэн бидэнд бага ч гэсэн ойртох болно.

Гэр орноо гэр бүлийнхэн маань дандаа эргэж ирэхийг хүсдэг ариун газар мэт болгоцгооё.

Гэр орноо санан мөрөөдөх нь

Та бүгдийн зарим нь өөрийн эцэг эхээс хулгайлагдан алс холын тосгонд аваачигдсан бяцхан хүүгийн тухай түүхийг санаж байгаа байх. Бяцхан хүү өөрийн эцэг эхээ мэдэхгүйгээр насанд хүрдэг. Том болоод төрсөн гэр орон эцэг эхээ санагалзан зүрхэндээ шаналдаг.

Гэвч түүний орон гэр хаана байна вэ? Түүний аав ээжээсээ салсан газар нь хаана байна вэ? Ядахдаа тэр тэдний нэрийг мэддэг байсан бол бага ч болов түүнд найдвар байхсан. Тэр өөрийн бага насныхаа дурсамжийг бага ч болов санахыг маш их хичээж байлаа.

Нэгэн наям гаригийн өглөө бүр хүн бүрийг дуудах мэт хангиндаг тосгоны сүмийн хонхны дуу санаанд нь зурсхийн орж ирэв. Залуу танил хонхны чимээг хайн тосгоноос тосгонд хэсүүлэн явж байлаа. Зарим хонхны дуу адил төстэй мэт санагдавч зарим нь түүний танил дуунаас шал өөрөөр сонсогдож байлаа.

Нэлээд хугацаа өнгөрсний дараа ядарч цөхөрсөн залуу нэгэн тосгоны сүмийн урд зогсож байв. Хонхны чимээ бусад олон сонссон дуунаас арай өөр танил сонсогдож байлаа. Хонх цохилох бүрт тэр маш анхааралтайгаар чих тавин сонсож, хүүхэд ахуй үеийнх нь дурсамжинд үлдсэн тэрхүү дууг таньжээ. Түүний нүдэнд нулимс цийлэгнэн, зүрх сэтгэл нь баяр баясгалангаар дүүрч түүнд талархах сэтгэл төрөв. Залуу өөрийн эрхгүй өвдөг сөхрөн унаж, хонх өлгөөстэй сүмийн орой тийш, бүр тэнгэр өөд харан “Бурхан минь баярлалаа. Би гэртээ байна.” хэмээн залбирав.

Би энэ дууны үгэнд дуртай.

Хамгаас хайрт гэр минь

Би хаа ч явсан,

Хүний нутагт эсвэл холын далай тэнгист,

Цаг мөч урсан өнгөрөх үед зүрх минь хайраар дүүрч,

Чамайгаа санан уйтгарлана!

Үзэсгэлэнт сайхан газар нутаг эргэн тойронд минь байвч, Үнэнч, нөхөрсөг олон найз нөхөд байвч

Баяр баясгалантай дуу намайг хүрээлэн байв ч,

Миний зүрх сэтгэл минь чамайгаа л санагалзан уйтгарлах юм.

Өөрсдийн гэр орноо аз жаргал, амар амгалан, хайрын өргөө болгож, Их Эзэний Ариун Сүнс орших газар болгохын төлөө хичээцгээе. Энэ бол та бүгдэд хүргэх миний залбирал, Есүс Христийн нэрээр, амен.

ТЭМДЭГЛЭЛ

1. David O. McKay, in *Family Home Evening Manual* (1965), iii.
2. In Nicholas Wood, “Thatcher Champions the Family,” *The Times*, May 26, 1988, 24.
3. “O Home Beloved,” *Hymns*, no. 337.

ДЭЛХИЙ ДАХИНАА ӨРГӨХ ТУНХАГ

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Тэргүүн Зөвлөл ба Арван Хоёр Төлөөлөгчийн Зөвлөл

Есүс христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмийн тэргүүн зөвлөл ба Арван Хоёр Төлөөлөгчийн Зөвлөлийнхөн бид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтийг Бурхан заяасан бөгөөд гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг чин сэтгэлээсээ тунхаглаж байна.

Бурхан бүх хүн төрөлхтөн, эрэгтэй эмэгтэй хүмүүсийг өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн. Хүн бүр тэнгэрлэг эцэг эхийн хайртай сүнслэг хүү, охин нь бөгөөд ийм учраас хүн бүр бурханлаг шинж чанар, хувь тавилантай юм. Хүйс бол хувь хүний мөнх бус байдлын өмнөх, мөнх бус болон мөнхийн амьдралын тодорхойлолт ба зорилгын салшгүй шинж чанар юм.

Мөнх бус байдлын өмнөх амьдралдаа сүнслэг хөвгүүд, охид Бурханыг Мөнхийн Эцэг хэмээн мэдэж, биширдэг байсан бөгөөд мөнхийн амьдралыг өвлөн авах тэнгэрлэг хувь заяагаа бүрэн дүүрэн ухааран ойлгож төгс төгөлдөр болон хөгжин дэвшихийн тулд бие махбодтой болж энэ дэлхийд амьдрах тухай Түүний төлөвлөгөөг хүлээн зөвшөөрсөн юм. Аз жаргалын тэнгэрлэг төлөвлөгөө нь насан эцэслэсний дараа гэр бүлийн холбоог мөнхжих боломж олгодог. Ариун Сүмүүдэд гүйцэтгэдэг нандин ёслол ба гэрээнүүд нь хувь хүмүүс Бурханы хүрээлэлд эргэн очих, гэр бүлүүд мөнхөд нэгдэх боломжтой болгодог.

Бурханы Адам, Ева хоёрт өгсөн анхны зарлиг нь тэд эхнэр нөхрийн хувьд эцэг эх болж чадах боломжийн талаар байлаа. Өөрийн хүүхдүүдээ, өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж газар дэлхийг дүүргэж хэмээсэн Бурханы зарлиг нь хүчин төгөлдөр байгааг бид тунхаглаж байна. Түүнчлэн үр удмаа үлдээх энэхүү нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр нөхөр болох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой хэмээн Бурхан зарлигласныг тунхаглаж байна.

Мөнх бус амьдралыг бий болгох арга зам нь Тэнгэрээс тогтоогдсон гэдгийг бид тунхагладаг. Бурханы мөнхийн төлөвлөгөөн дэх амьдралын цэвэр ариун байдал болон үүний чухал ач холбогдлын талаар бид батлан хэлж байна.

Нөхөр, эхнэр хоёр нь бие биенээ болон үр хүүхдээ хайрлан, халамжлах албан ёсны хариуцлага хүлээнэ. “Үр хүүхэд бол Их Эзэний өв юм” (Дуулал 127:3).

Эцэг эхчүүд хүүхдүүдээ хайраар болон зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлж бие бялдар болон оюун санааных нь хэрэгцээг хангаж, бие биенээ хайрлан, үйлчилж, Бурханы зарлигуудыг дагаж, хаана ч амьдарсан хуулиа хүндэтгэн сахидаг иргэд байхыг зааж сургах нандин үүрэгтэй юм. Эхнэр, нөхөр—эцэг, эхчүүд үүргээ хэрхэн биелүүлснээрээ Бурханы өмнө хариуцлага хүлээнэ.

Гэр бүл Бурханаас заяагддаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүл болох нь Түүний мөнхийн төлөвлөгөөний зайлшгүй нэг хэсэг юм. Хүүхдүүд нь гэр бүлийн дотор төрж, гэрлэлтийн тангаргаа үнэнчээр сахидаг эцэг эхээр өсгүүлэх эрхтэй юм. Их Эзэн Есүс Христийн сургаалд үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно. Аз жаргалтай гэрлэлт болон гэр бүлүүд нь итгэл, залбирал, наманчлал, оршоол, хүндэтгэл, хайр энэрэл, өрөвч сэтгэл, ажил хөдөлмөр ба гэр бүлээрээ үр бүтээлтэй ажиллах зарчмуудын дор оршин амьдарна. Тэнгэрийн загвараар эцэг нь өрх гэрээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, амьдралын хэрэгцээг зүйлсээр нь хангаж гэр бүлээ хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал юм. Энэхүү нандин үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой. Тахир дутуу болох, нас нөгчих болон бусад нөхцөл байдалд хувь хүн зайлшгүй дасан зохицох шаардлага гарч болно. Төрөл төрөгсөд нь хэрэгтэй үед туслан дэмжвэл зохино.

Ариун явдлын гэрээгээ зөрчин, хань ижил, үр хүүхэдтэйгээ зүй бусаар харьцсан, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй хувь хүн хожмын нэг өдөр Бурханы өмнө өчиг мэдүүлэх болохыг бид анхааруулж байна. Түүнчлэн гэр бүлээ сарниулбал эрт эдүгээгийн бошиглогчдын зөгнөн хэлснээр хувь хүн, нийгэм, улс үндэстнүүдэд гай гамшиг авчрах болно гэдгийг бид сануулж байна.

Итгэл хүлээсэн иргэд, төрийн албан хаагч та бүхнийг нийгмийн үндсэн нэгж болох гэр бүлийг бэхжүүлэн авч явах эдгээр арга замыг ямагт хэрэгжүүлэгтүн хэмээн уриалан дуудаж байна.

Энэхүү тунхгийг Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли Юта дахь Солт Лэйк Ситид 1995 оны 9-р сарын 23-нд болсон Нийгмийн Халамжийн Бүлгийн Ерөнхий Уулзалтан дээр захиасынхаа нэгэн хэсэг болгон уншсан юм.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

